



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 18 өдөр

Дугаар Н/44.


Улаанбаатар хот

Г Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны
зааварчилгааг шинэчлэн батлах тухай


Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Зам, тээврийн хөгжлийн төвийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.7.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ Нь:

1. “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын үйл ажиллагаанд мөрдөгдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллахыг нийт ажилтнууд албан хаагч наарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн /Б.Мөнхбаяр/-т үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Б.Батсайхан/-т даалгасугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан төвийн захирлын 2020 он 05 дугаар сарын 21-ний өдрийн А/56 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Х.ПҮРЭВЖАРГАЛ



Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 04 дүгээр сарын 18-ний
өдрийн 1/1 дугаар тушаалын хавсралт

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨХ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа №1
2. Инженер, техникийн ажилтануудын аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгаа №2
3. Оффисын орчины хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн заавар, зааварчилгаа №3
4. Няравын аюулгүй ажиллагааны зааварчилгаа №4
5. Лабораторийн техник, аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа №6
6. Лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй ажиллах техник аюулгүй ажиллагааны зааварчилгаа №6
7. Жолооч нарын ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа №7
8. Харуул хамгаалалт, жижүүрийн мөрдөх аюулгүй ажиллагааны зааварчилгаа №8
9. Үйлчилгээний ажилтны ажлын чиг үүрэг, аюулгүй ажиллагааны зааварчилгаа №9
10. Өндөрт ажиллах үеийн аюулгүйн ажиллагааны зааварчилгаа №10
11. Цахилгааны аюулгүй ажиллагааны зааварчилгаа №11
12. ТАЦ-ын ажилтнуудын чиг үүрэг аюулгүй ажиллагааны зааварчилгаа №12
13. Хяналтын инженерийн ажлын чиг үүрэг, аюулгүй ажиллагааны зааварчилгаа №13
14. Хөдөлгөөнт эргүүлийн ажлын чиг үүрэг, аюулгүй ажиллагааны зааварчилгаа №14
15. Зөөврийн авто пүүгээр ажиллах үеийн хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааны зааварчилгаа №15
16. Техник ашиглалтын түвшин тогтоох ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа №16
17. TATT судалгаа, шинжилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй ажиллах техник аюулгүй ажиллагааны зааварчилгаа №17
18. Машин механизм ашиглалтын аюулгүй ажиллагааны зааварчилгаа №18
19. Диспетчер, операторын аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгаа №19
20. Замын машин механизмын тоног төхөөрөмжтэй ажиллах үеийн аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа №20

Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн
17/11 дугаар тушаалтын 18
батлагдсан зааварчилгаа №1

АТДС-925

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЗААВАРЧИЛГАА

- Ажилтан нь ажил үүргээ гүйцэтгэхдээ хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаанд тусгагдсан зааврыг мөрдөн ажиллана.
- Төвд мөрдөгдөж буй дотоод дүрэм, журам, зааврыг судалж мэдсэн байна.
- Аливаа ажлыг гүйцэтгэх үедээ хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэл ажлын онцлогт тохирсон багаж, хэрэгслээр хангагдсан байна. Олгогдсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг хайллан хамгаалж, бүрэн бүтэн байдлыг ханган ажиллах үүрэгтэй.
- Ажилтан бүр ажил үүргээ биелүүлэх явцад аюулгүй ажиллагааны нөхцөл зөрчигдэж хүний амь нас, эрүүл мэндэд серөг, аюултай байдал бий болсон тохиолдолд ажлаа нэн даруй зогсоож, энэ талаар удирдлага болон түргэн тусламжийн 103, онцгой байдлын газрын 101 дугаарын утсанд яаралтай мэдэгдэнэ. (энэ үед гал гарсан байрлал, мөн өөрийн овог нэрийг зайлшгүй мэдээлэх шаардлагатай)
- Архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн мансуурсан эрүүл мэндийн хувьд чадваргүй тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа шаардсан ажил үүрэг гүйцэтгэхийг тус тус хориглоно.
- Ажилтан нь ажил үүргийн хуваарийн дагуу шинэ тоног төхөөрөмж дээр ажиллах, аймаг орон нутагт албан томилолтоор явахаас өмнө давтан зааварчилгааг авсан байна.
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, журам, зааварт заагдсан зүйлийг зөрчин ажилласан буюу ажиллуулсан хэн боловч зохих хууль журмын дагуу хариуцлага хүлээнэ.

...оОо...

Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн
..А/44 дугаар тушаалтын
батлагдан зааварчилгаа №2

ДТАДРСНЯ СОЛТ

ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТАНУУДЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР, ЗААВАРЧИЛГАА

Ажил эхлэхийн өмнө ажлын хувцас бүрэн зөв өмсөж бусад ажиллагсдад үлгэр жишээ үзүүлж, манлайлах. Хөдөлмөрийн аюулгүй байдал эруул ахуйн дүрэм, журам, заавар, зааварчилгааг чанд мөрдөж ажиллах. ХАБЭА-н сургалтад хамрагдсан байх. Хариуцан ажилдаг ажилтандаа өдөр тутмын ажил үүрэгтэй нь уялдуулан аюулгүй ажиллагааны зааварчилгаагтогтмол өгөх чадвартай байх.

1. Ажлын байр, тоног төхөөрөмжүүдийг шалгаж, аюулгүй. цэвэр, эмх цэгцтэй байлгана.
2. Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл, багажуудыг шалгаж, шаардлага хангахгүй тохиолдолд анхан шатны хяналтын дэвтэрт бичиж, зохих арга хэмжээг авна.
3. Зөрчлийг арилгаж, ажлын байрны аюулгүй байдлыг хангах боломжгүй бол аюулгүй байдлыг хангах хүртэл ажлыг эхэлж болохгүй.
4. Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл, багажийг зориулалтаар зааврын дагуу хэрэглэх талаар бусад ажилтнуудад үлгэрлэдэг, зөв хэрэглээгүй үед шаардлага тавьдаг байх ёстай.
5. Шинэ тоног төхөөрөмж, машин механизм, багаж хэрэгсэл дээр ажиллахын өмнө тэдгээрийн технологийн заавар болон техник ашиглалтын заавартай танилцаж, зааврын нь дагуу ажиллуулна.
6. Ажлын байранд шаардлагатай заавар, дүрэм, анхааруулах ба хориглох зүйл, зураг схем, плакат, зөвлөмжийг байрлуулах зэрэг техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.
7. Гэнэтийн аюул учруулж болзошгүй ажлын байруудыг урьдчилан шалган үзэж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг цаг алдалгүй авна.
8. Төв цэг салбаруудад ашиглагдаж байгаа цахилгаан тоног төхөөрөмж шугам сүлжээ нь "Цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалтын дүрэм". "Цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрэм" ба галын аюулгүйн шаардлагыг хангасан байх ёстай.
9. Шугам сүлжээ кабель цахилгаан үүсгүүр, хөдөлгүүр, гэрэлтүүлэг бусад тоног төхөөрөмжийн сонголт, ашиглалтын байдалд хяналт тавина.
10. Төв-ийн бүх тоног төхөөрөмжинд техник ашиглалтын паспорт хөтөлж, хийгдсэн засвар үйлчилгээг бичиж байна.
11. Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх зааварчилгаа авч, зүрхний гаднах иллэг, хиймэл амьсгал хийх, цус алдалтыг тогтоох, шарх боох зэрэг эмнэлгийн анхан шатны тусламжийг зөв шуурхай үзүүлэх арга барилд дадлагажсан байна.


12. Ажлын байранд, ялангуяа лабораторид ахуйн зүйл хэрэглэх (хүнсний зүйл хэрэглэх, үс самнах, хумс авах гм), тамхи татах, согтууруулах ундаа хэрэглэх, задгай сэнс ажиллуулахыг хориглоно.

13. Лабораторид ажиллах үед хянамгай байдал сэрэмжийг дээд зэргээр хангана.

14. Лабораторид хэрэглэсэн ажлын хувцсыг өөрийн хувцастай хамт хадгалах, лабораторид ажилласны дараа бусад өрөө тасалгаагаар сэлгүүцэн явахыг хориглоно.

15. Аваар, ослын үед ажиллахдаа ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, хамгаалах хэрэгслийг бүрэн зөв өмсөж, хэрэглүүлж ажиллуулах.

...оОо...



Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн
11 дугаар тушаалтын хавсралтаар
батлагдсан зааварчилгаа №3

АТД4979

ОФФИСЫН ОРЧИНЫ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХҮЙН ЗААВАР, ЗААВАРЧИЛГАА

Ерөнхий зүйл

Байгууллагын конторт ажил үүргээ гүйцэтгэж байгаа ИТА нар нь аюулгүй, үр бүтээлтэй ажиллах нөхцөл бололцоог хангасан орчин, техник хэрэгслээр хангагдсан оффиссын орчинд, аюулгүй ажиллагааны дүрэм стандартыг баримтлан ажиллах үүрэгтэй.

Оффисын орчин гэдэгт: зайд талбай, гэрэлтүүлэг, агааржуулалт, дулаан, чийгшилт, тасалгааны өнгө будаг, сандал ширээ, компьютер, техник хэрэгсэл гм. ажиллах орчин нөхцөл техник хэрэгслийг хамтад нь ойлгоно. Зарим оффисын орчин хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартуудын шаардлага хангаагүйгээс ажилтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг. Жишээ нь: толгой өвдөх, нозоорох, нүд, чих, хамар, сонсгол өвчлөх, стресс гэх мэт

Ажлын байрны стандарт нь:

- Нэг хүнд ноогдох зайд талбай нь бүх тавилга хэрэгслээ оруулаад $6m^2$ эзэлхүүн нь $20m^3$
- Дуу чимээ 50 - 60дб
- Өрөөний темпратур дунджаар зун 20с өвөл 25с байх
- Гэрэлтүүлэг 300 - 500люкс
- Байгалийн гэрэлтүүлгийг ашиглах
- Бүх талбайг жигд гэрэлтүүлэх
- Хэсэгчлэн гэрэлтүүлэх
- Гэрлийн чийдэнг сард багадаа 1 -2 удаа цэвэрлэж байх
- 30 минут тутамд 1 -3 минут агаар оруулах
- $20^{\circ}C$ температуртай өрөөнд 50-65% -ийн агаарын чийгшилтэй байлгана.
- Агааржуулалт 0,1 - 0,2м/сек

Оффисын гэмтэл

Халтирах, унах, тээглэх шалтгаан нь: хунирсан шалны дэвсгэр, явах гадарга тэгш бус байх, чийгтэй/халтиргаатай гадарга, замбараагүй тавьсан эд зүйлс/сонин, сэтгүүл, хог, ургамал-таримал , уртасгагч утас, харанхуй-бүүдгэр, өндөр босго, шат

Халтираас сэргийлэхийн тулд: Аюулгүй алхах чадварыг эзэмших, ойрхон алхаж биеийн тэнцвэрээ хадгалах, чийгтэй гадаргыг даруй цэвэрлэх, зөвлөн гадарга дээр илүү анхааралтай байх. Тохирох гутал өмсөх.

Тээглэхээс сэргийлэхийн тулд: Хаана явж байгаагаа харах, анхаарал хандуулах, ажлын хэсгийг гэрэлтэй, цэвэр байлгах, тавилга, тоног төхөөрөмжийг ажлын байрны хүний явах хэсэгт саадгүй зохион байгуулах, явах хэсгээс цахилгааны залгуур уртасагчийг холдуулах, сул утаснаас үүсэх эрсдлийг тооцох.

1. Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа зааварчилгаа

КОМПЬЮТЕР Компьютертэй ажлын байранд тавигдах эрүүл ахуйн шаардлага

- Агаарыг чийгшүүлж, агааржуулж байх
- Компьютертэй нэг ажлын байрны талбай 6 м²-аас, эзлэхүүн 20 м³-ээс тус тус багагүй байх.
- Нэг мониторын араас нөгөө мониторын дэлгэц хүртэлх хоорондын зайд 2 метрээс багагүй байх.
- Зэрэгцсэн хоёр ажлын байрны монитор хоорондын зайд 1,2 метрээр багагүй байх.
- Мониторын дэлгэц ажилтан хоёрын хоорондын зайд 0,5 метрээс их /0,6-0,7 метр/ байх.
- Ажлын байрны гэрэлтүүлэг 300-500лк байвал зохимжтой бөгөөд дэлгэц дээр ойхгүй байна.
- Ширээний өндөр нь сандал дээр сууж байхад тохойн түвшинд байх. Компьютер дээр ажиллах аюулгүй ажиллагааны шаардлага
- Компьютер газардуулгатай байна.
- Ажиллаж байгаа компьютерын металл хэсэгтхүрч болохгүй.
- Шингэн кристалл дэлгэцтэй компьютер өргөнөөр ашиглах.
- Цацраг идэвхтэй туяаны хоолойн зарчмаар ажилладаг мониторын кадрын давтамж 75гц-ээс багагүйгээр тохируулах шаардлагатай бөгөөд шингэн кристалл дэлгэцэд кадрын давтамж БОгц байж болно.

Компьютер дээр ажиллахад гарцаа зөв байрлуулахад анхаарах хэрэгтэй. Бугуйн шөрмөсний гэмтэл нь компьютерын гарны зохимжгүй дизайн, байрлал, хэрэглээнээс шалтгаалдаг. Гарыг зөв байрлуулахад:

- Ширээ сандлын өндрийг нуруу нугарахгүй байхаар тохируулах
- Компьютерын гарны тохирсон тавиурыг хэрэглэх
- Тохирох зайд биеэ зөв байрлуулах

2. Хэвлэх төхөөрөмж ашиглах техникийн аюулгүй ажиллагаа зааварчилгаа

Хэвлэгч машин нь нарийн төвөгтэй цахилгаан хэрэгсэл учир түүнтэй ажиллахдаа галын болон цахилгааны аюулгүй байдлын стандартын шаардлагыг биелүүлж ажиллах хэрэгтэй.

Лазерын хэвлэгч машин гэрэл мэдрэгч барбан дээр дүрс үүсгэх үед цаас халж тонер наалдах агшинд агаарт янз бүрийн хорт бодис ялгардаг. Лазерын хэвлэгч машин ажиллах үед ажлын байрны агаарт

- Озон
- Азотын исэл
- Нүүрстөрөгчийн исэлгийн агуулга ихсэх мөн бусад химиин нэгдэл ялгарах магадлалтай.

Принтерийн хор /тонер/ нь нүд болон арьсыг гэмтээж болох хортой, түүгээр амьсгалвал өвчлөл, золгүй тохиолдолд өртөж болзошгүй

- Дууссан хорыг сэгсэрч дахин хэрэглэхгүй байх
- Мэргэжлийн хүнээр хорыг цэнэглүүлж байх
- Галын аюулгүй байдлыг хангах хэрэгтэй

Цаас гацах, тээглэх үед принтерийг унтрааж байх мэргэжлийн хүн л биш бол задлахгүй байх, задалсан үед маск хамгаалах хэрэгсэл зүүх. Лазерын туяагаар дүрсийг цаасан дээр буулгадагыг мартаж болохгүй. Лазерын шууд болон ойсон туяа нүдэнд тусвал харааг буцалтгүйгээр гэмтээнэ. Лазерын хэвлэгч машинтай ажлын байранд агааржуулалтын системтэй байх эсвэл тогтмол салхилуулж чийгтэй цэвэрлэгээ хийх хэрэгтэй. Лазерын хэвлэгч машиныг тасралтгүй ажиллагаатай цахилгааны тэжээлд тогтмол залгах хэрэггүй. Хэвлэгч машин ажиллах үед гардаг дуу чимээний зөвшөөрөгдөх хэмжээ тогтоогдоогүй.

Хувилагч /канон/ ашиглах үеийн аюулгүй ажиллагаа зааварчилгаа

Хувилагч техник нь ихэнх тохиолдолд лазерын хэвлэгч /принтер/-тэй адил төсөөтэй байдаг боловч түүнээс хэд дахин илүү хүчин чадалтай тул ялгаруулах хорт бодис нь тэр хэмжээгээрээ их байдаг. Хувилагч техникийн ажиллагааны үндсэн зарчим хэвлэгчтэй төсөөтэй учир хүний биед үзүүлэх сөрөг нөлөө нь адилхан байдаг. Иймээс хувилагч техник, хэвлэгч машины аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага ижил гэж ойлгож болно. Гэхдээ сонгодог хувилагч техник нь лазерын хэвлэгчийн ажиллагааны зарчимд сууринсан байдаг боловч зарим талаар ялгаатай байдаг. Үндсэн ялгаа нь гэрэл мэдрэгч барабан дээр дүрс үүсгэх аргаараа өөр байдаг юм. Энэ арга нь агаарт ялгарах озон, азотын ислийн агуулгыг илүү нэмэгдүүлдэг юм. Хувилагч техниктэй харьцахад анхаарах аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зарим шаардлага. Үүнд:

- Хувилагч техник дээр жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдийг ажиллуулахыг хориглоно.
- Хувилагч техник хэрэглэдэг хорноос ялгарах тоосонцор агаарт 3,5мг/м3 -ээс бага байх ёстой.

- Хувилагч техник хана, баганаас 0,6 метрээс, үйлчлэх зайд 1 метрээс тус тус багагүй байх шаардлагатай.
- Хувилагч техникийн озоны шүүлтүүрийг зөв сонгож тавих, түүнийг байнга шалгаж байх хэрэгтэй.
- Хувилагч техникийн хаалт тагийг байнга шалгаж байх хэрэгтэй.
- Хувилагч техникийг ажлын ширээнд ойр байрлуулахгүй байх боломжтой тохиолдолд тусгай тасалгаанд байрлуулах.
- Хувилагч техникийг агааржуулах системтэй эсвэл агаар солилцох боломжкоор хангагдсан өрөөнд байрлуулах. Офиссын ажлын байранд хэвлэгч, хувилагч техникийн хор, цэвэрлэгээний бодис бичгийн засварлах шингэн зэрэг байдаг. Ажилтан наарт эдгээр бодисын эрсдэлийн талаар мэдлэгтэй байх шаардлагатай.

Офиссын ажилтны завсарлагааны үед хийх биеийн хөдөлгөөний дасгалыг тогтмол хийж хэвшвэл ажлын байрны регономик/эргономик/ хүчин зүйлээс хүний эрүүл мэндэд нөлөөлөх аюулаас урьдчилан сэргийлэх.

3. Цахилгааны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Цахилгаан хэрэгслийг тогтмол шалгаж, зохистой хэрэглээгүй тохиолдолд аюул үүснэ.

- Цахилгааны гэмтэл, сэжигтэй хэвийн бус ажиллагааны байдлыг мэдээлэх.
- Цахилгаан хэрэгсэл, компьютерийн хэрэгсэлд шингэн зүйл хүргэхгүй байх.
- ЧИЙГТЭЙ ГАРААР ХҮРЭХГҮЙ БАЙХ!
- Зөвшөөрөгдөөгүй тоног хэрэгсэл хэрэглэхгүй байх.
- Хэрэглээгүй үед цахилгаан хэрэгслийг салгаж байх.
- Цахилгааны залгуурыгсалгах!
- Цахилгааны залгуурыг хэт ачаалахгүй байх.

Уртасгагч утсыг хивсний доогуур эсвэл явган гарцаар хөндлөн байрлуулахгүй байх.

- Утас, кабельд тээглэх аюулаас сэргийлэх
- Хоёр уртасгагч утсыг орооцолдуулахгүй байх
- Гал гарах аюултай.
- Урт хугацаанд уртасгагч утас хэрэгтэй бол байнгын цахилгаан утас шаардлагатай.
- Ажил дуусч тарах үед цахилгаан хэрэгслүүдийг нэг бүрчлэн салгаж үлдээх

4. Гар утас ашиглах аюулгүй ажиллагаа зааварчилгаа

Дэлхийн олон оронд явуулсан судалгаанд 10 жил гар утас ашигласан хэрэглэгч чихний хорт хавдрын өвчлөлд өртөх магадлал 4 дахин ихсэх, тархины хавдар хавдар үүсэх магадлалыг нэмэгдүүлдэг гэсэн дүгнэлтэд хүрчээ. Мөн 2 минут гар утсаар ярьсан хүүхдийн тархины био цахилгаан идэвхжил ярьж дууссанаас хойш 2 цагийн турш өөрчлөлтэй байдаг нь батлагдсан байна. Орос улсын эрүүл ахуйн шаардлагаар 18 нас хүрээгүй хүүхэд болон

зүрхний хэмийн жолоодлогыг тайруулсан хүмүүсийг гар утас хэрэглэхийг хязгаарладаг. Гар утас суурин утаснаас ялгаатай нь тийм ч аюулгүй эд биш юм. Ямар ч гар утас өндөр давтамжтай цахилгаан соронзон туяаны үүсвэрт тулгуурласан байдаг. Гар утасны туяаны хүч бага боловч арьсыг халаах эсийг гэмтээх чадалтай. Анхаарах зүйл:

- Гар утсыг энгэртээ болон гэдэсний хажууд авч явахгүй байх.
- Нэг удаа 3 минутаас илүү ярихгүй байх, 15 минутын завсарлагаатай ярих
- Сүлжээ муу үед удаан ярихаас татгалзах.
- Машин дотор ярихгүй байх эсвэл антейн/антен/ ашиглах.
- Мессеж бичих нь ярихаас хамаагүй бага цацрагийн нөлөөтэйг анхаарах. Ямар ч ажлын байранд хортой, аюултай хүчин зүйл байдаг боловч тэр болгоныг үйлдвэрлэгч баримтжуулаагүй байдаг юм. Иймээс ажлын байранд байгаа аливаа техник хэрэгслийнхээ тухай та өөрөө судалж мэдлэгтэй байх нь танд сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх боломж олдоно.

5. Ачааг гараар өргөх, зөөх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1. Баглаа боодлой болон бусад ширхэгийн ачааг зөвөрлөхдөө гарцаа шархлуулахгүйн тулд бүгдийг нь урьдчилан сайтар шалгаж үзэх хэрэгтэй, / төмөр баглааны үзүүр, хадаасанд гарцаа урах, зүсэх эрсдэлтэйг анхаарах./ Хайрцгийг буюу боодлыг хураасан газраас авахдаа хажууд нь байгаа ачаа унахгүй, тогтвортой байдалд байгаа эсэхийг шалгах хэрэгтэй. Ачааг зөвхөн хураалтын дээд талаас авбал зохино. Ачааны хүнд, хөнгөнийг сайн тохируулах. Хэт хүнд, овор ихтэй ачаа өргөхгүй байх.
2. Ачаандаа үнэлгээ хийх-Өргөж явах хооронд ачааны зарим хэсэг хөдөлж болох эсэх /бөөрөнхий зүйлс, лонх, хуйлсан зүйл гэх мэт/.
3. Хөлөө зөв тавих. /нэг хөлөө ачааны ард, нөгөө хөлөө явах гэж байгаа зүг рүүгээ харуулж ачааныхаа хажууд тавь./
4. Ачаанд хүрэх гэж бүсэлхийгээрээ бүү тонгой. Өвдгөө нугал. /дараа нь доошоо тонгойж ачаандаа хүр./

...ооо...

Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн
А/А/А дугаар тушаалын хавсралтаар
батлагдсан зааварчилгаа №4

ДТД 4978

НЯРАВЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, технологийн горимыг мөрдөж ажиллана.
- Ар гэртээ сайтар амарч согтууруулах ундаа болон мансууруулах бодисын нөлөөнөөс ангид ажилдаа ирнэ.
- Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцаж, дэвтэрт тэмдэглэнэ.
- Гадуур хувцсыг зориулалтын шүүгээ, өлгүүрт хийж, ажлын тусгай хувцсыг бүрэн хэрэглэнэ.
- Ажлын байрны лац ломбо болон цахилгаан хэрэгслүүдийн хэвийн ажиллагааг шалгана. Гэмтэл, үл тохирол илэрвэл холбогдох ажилтанд мэдэгдэж, засч арилгасны дараа ажил үүргээ эхэлнэ.
- Нярав нь ажил үүргийн хуваарьт тусгагдсан буюу ажил удирдагчийн заасан ажлыг гүйцэтгэхтэй холбогдсон аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцаж, дэвтэрт гарын үсгээ зурна.
- Агуулах нь байнга эмх цэгтэй. Цэвэрхэн байх бөгөөд гаднын хүн орж болохгүй.
- Агуулахын байр нь хангалттай гэрэлтүүлдэг, гадна талдаа хамгаалалттай гэрэлтүүлэгтэй байна. Гэрлийн монтаж нь далд, цахилгааны утасны диаметр нь ачаалал даахуйц байна.
- Агуулахын гэрлийн унтраалга, залгуурууд нь технологийн дагуу хийгдсэн, контакт нь найдвартай, сул биш байх хэрэгтэй.
- Агуулахын тавиурууд нь бат бөх хийгдсэн байна.
- Агуулахад хэрэглэх зөөврийн шат нь бат бөх, хөдөлгөөнгүй, дээд талын тавиурт байгаа бараа, эд зүйлийг авахад хүрэлцэхүйц өндөртэй байх хэрэгтэй.
- Тавиур, тавцан руу бүү авир. Дээд талын тавиурт хүрэхийн тулд шат, тавцан, гишгүүр ашигла.
- Сэлбэг хэрэгсэл, эд хогшлыг хураахдаа нурж унахааргүй, цөөн тоогоор давхарлаж тавина.
- Турбо, лааз, торх зэрэг өнхрөх зүйлсийн наагуур хаалт хийх буюу бэхэлсэн байна.
- Жижиг, хүнд зүйлсийг дээд тавиурт нүдэнд харагдахуйц тавина.
- Химиин бодисыг хадгалахдаа зохих агааржуулалт, температурыг хангах болон бусад хамгаалах арга хэмжээг авсан байна. Зарим бодисуудыг хамтад нь хадгалж болдоггүй сана.
- Бараа материалыг хөлд тээглэхгүй, тавиураас илүү гарган хурааж болохгүй. Тавиур дээр тавьсан эд зүйлсийн хаяг, нэр, тоо ширхгийг нүдэнд ил харагдахуйцаар бичиж тавьсан байна.
- Шатах, тослох, тэсэрч дэлбэрэх материалыг тусгай зориулалтын байранд хадгална. Шатах, тослох, тэсэрч дэлбэрэх материалын агуулахын гадна, дотор талд анхааруулах санамжийг байрлуулах шаардлагатай Агуулахад галын дохиолол байх шаардлагатай.
- Онцгой байдлын үед агуулахаас түргэн гарах боломжтой байна. Тавиур хоорондын зай, эгнээ зэргийг бүү битүүлж мухарла.
- Агуулах дотор болон агуулах орчимд гал унтраах төхөөрөмж заавал тавьсан байна.
- Агуулах доторх галын хор, галын хоолой, бусад төхөөрөмжийг халхалсан байдлаар барааг бүү хураа.

Зам, тээврийн Хөгжлийн төвийн захирлын
2022 оны 04 дугаар сарын 16-ний өдрийн
14 дугаар тушаалын хавсралтаар
батлагдсан зааварчилгаа №5

АТД 4979

ЛАБОРАТОРИЙН ТЕХНИК, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЗААВАРЧИЛГАА

- Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хувцас хэрэгслийг бүрэн өмсөж, аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцаж гарын үсэг зурна. Тухайн өдөр аюулгүй ажиллагааны зааварчилгаа аваагүй ажилтныг ахлах шинжээч ажилд хуваарилахыг хориглоно.
- Ажил эхлэхээс 10 минутын өмнө өрөөний цонхыг онгойлгон агаар сэлгэлтийг тогтмол хийх.
- Туршилт хийж байх хугацаанд туршилтанд саад болж байгаа зүйлсийг холдуулж ажиллах нөхцөлөө бүрдүүлэн аюулгүй ажиллагааг бүрэн хангаж ажиллана.
- Лаборатори тус бүрийн өрөө хариуцагч ажилтан тухайн лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хариуцан ажиллана.
- Лабораторийн орчинд тамхи татахыг хориглоно.
- Гал унтраагуурыг ашиглах чадвартай байх.
- Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй ажиллах техникийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллана.
- Машин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, аппарат, тэдгээрийн хяналт хамгаалалт автомат залгуур, хөдөлгөөн дамжуулах эд ангийг шалгаж гэмтсэн тохиолдолд туршилт шинжилгээ хийхгүй байх.
- Тоног төхөөрөмжийг залгаж салгахдаа чийгтэй нойтон гараар харьцахгүй байх.
- Цахилгааны утас сuldсан байх, шалбарч ил гарсан байх зэргээс болгоомжлон ажиллах, гэмтлийг тухай бүрт нь арилгах.
- Багаж тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийхдээ удирдах албан тушаалтан, нягтлан бодогчид хандаж шийдвэрлүүлэн, засвар үйлчилгээг хийлгэнэ.
- Ажилтан бүр ажил үүргээ биелүүлэх явцад аюулгүй ажиллагааны нөхцөл зөрчигдөж нүхий амь нас, эрүүл мэндэд сөрөг, аюултай байдал бий болсон тохиолдолд ажлаа нэн даруй зогсоож, нэн талаар удирдлагадаа яаралтай мэдэгдэнэ.
- Ажлын байранд архидан согтууруулах ундаа хэрэглэх, ажлын бус цагаар гадны хүн оруулахыг хатуу хориглоно.
- Ажил дууссаны дараа багаж тоног төхөөрөмжийн унтраан, бүрэн бүтэн байдлыг шалгаж хадгалалтын нөхцөлийг ханган, өрөөний түлхүүрийг жижүүрт хүлээлгэн өгнө.

...оо...

Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн
1741 дугаар тушаалтын хавсралтаар
батлагдсан зааварчилгаа №6

ДТА4974

ЛАБОРАТОРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАГАЖ ХЭРЭГСЭЛТЭЙ АЖИЛЛАХ ТЕХНИК АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

1. Лабораторийн шилэн сав хэрэгсэлтэй ажиллах техник аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1. Лабораторийн туршилт шинжилгээнд сайтар угааж цэвэрлэсэн цэвэр шил савыг хэрэглэнэ.
2. Лабораторийн шилэн савыг халаахын тулд элсэн плитка, битүү ширэмтэй плитка асбест тор хэрэглэнэ.
3. Лабораторийн шилэн савыг шууд гал дээр тавьж халааж, хатааж болохгүй.
4. Халуун шилэн савтай харьцаадаа анхаарал болгоомжтой ажиллах хэрэгтэй.
5. Замын битум, нефтын гаралтай материалыг халаахдаа битум халаагч элс, хайрга, дайрга гэх мэт эрдэс гаралтай материалыг халаахдаа төмөр сав хэрэгтэй.
6. Хагарч гэмтэх шилэн савыг хэрэглэхдээ анхаарал болгоомжтой ажиллах хэрэгтэй.
7. Ажил дууссаны дараа шилэн сав хэрэгслийг сайтар угааж арчиж цэвэрлэсэн дараагийн туршилтанд бэлэн болгож тавина.

2. Лабораторид тэсрэх аюултай бодистой ажиллах техник, аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1. Дөл амархан авалцдаг ба шатамхай шингэн бодисыг Лабораторид зузаан ханатай шилэн саванд хийж сэруүн орчинд байлгана.
2. Шатамхай шингэн агуулсан шилэн савыг халаах бодисыг хэрэгслэ хүний гараас хол ханатай шилэн саванд хийж сэруүн орчинд байлгана.
3. Дөл амархан авалцдаг шингэний литрээс илүүгүйгээр савлаж болохгүй. Их хэмжээгээр савласан тохиолдолд шилэн савны гадуур галд тэсвэртэй төмөр хайрцганд байрлуулна.
4. Галын аюултай шингэн бодисыг асгарсан тохиолдолд бүх халаах хэрэгслүүдийг унтраан асгарсан газар элс асгаж бохирдсон элсийг модон хүрзээр цэвэрлэнэ.
5. Шатамхай шингэн бодис дөл авалцсан тохиолдолд бүх халаагч хэрэгсэл, салхивчийг яаралтай унтрааж гал унтраах шаардлагатай арга хэмжээг авна.
6. Мөн галын аюултай бодисуудыг тасалгаанаас хурдан зайлцуулна.
7. Шатамхай шингэн шатсан тохиолдолд нүүрс хүчлийн гал унтраагуур хэрэглэж элсээр мөн даавуугаар цохиж унтраана.
8. Модон эдлэл шатсан тохиолдолд гал унтраах бүх аргыг хэрэглэж болно.

3. Лабораторийн жинтэй ажиллах техник, аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1. Лабораторийн жингүүд тэгш, тогтвортой, бат бэх хөдөлгөөнгүй суурилагдсан байх ёстой.
2. Материалын дээжийг шинжлэхдээ дараах шаардлагыг биелүүлсэн байна. Үүнд:
 - Тухайн жинг баруун тавган дээр дээжийг зүүн тавган дээр байрлуулна.
 - Нунтаг, шатамхай, наалдамхай материалыг тусгай жинлэсэн сав хэрэглэж жинлэнэ.
 - Жингийн даацын хэмжээг хэтрүүлж болохгүй.
 - Жингийн туухайг томоос нь эхэлж байрлуулна.
 - Дээж болох туухайг аажим байрлуулна.
 - Жингийн таваг дээр туухайг удаан хугацаагаар байрлуулан орхиж болохгүй.

3. Ажил дууссаны дараа жинг цэвэрлэж дараагийн туршилтанд бэлтгэж орхино.

4. Лабораторид битум асфальтбетон хольцтой ажиллах техник, аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1. Лабораторид битумыг ажлын хэм хүртэл халаахдаа дараах тоноглолуудыг хэрэглэж болно. Үүнд:
 - Төмөр болон шаазан аяга сав
 - Хатаах шүүгээнд байрлуулсан элсэн ба битүү ширэмтэй плитка
 - Цахилгаан плитка дээрх кастрюл сав
 2. Лабораторийн дээжний аяга кастрюл дахь битумын түвшин савны ирмэгээс 8-10 см зээс байгагүй хэмжээнд байна.
 3. Өтгөн битумыг төрөл уусгагчаар шингэрүүлж хэрэглэхийн тулд 100-110 хэм хүртэл хөргөнө.
 4. Уусгагчийг хийж шингэрүүлэхдээ халаах хэрэгслээс авч элсэн суурин дээр байрлуулах ба бусад халаагч цахилгаан хэрэгслүүдийг цахилгаан гүйдлээс салгасан байна.
 5. Шатаж байгаа битумыг унтраахдаа хуурай элс нүүрс хүчлийн гал унтраагуурыг хэрэглэнэ. Ус хэрэглэж болохгүй.
 6. Халуун битум ба хольц арьсанд хүргэвэл керосинээр арчих буюу түлэгдсэн хэсэгт илэгдлийн эсрэг түрхлэгтэй саармагжуулах боолт хийнэ.
- 5. Хатаах зуухтай ажиллах техник, аюулгүй ажиллагааны зааварчилгаа**
1. Ажил эхлэхийн өмнө ажлын хувцас, халуун тусгаарлагчтай бээлий өмсөж, хошуувч зүүсэн байна.
 2. Зуухыг хүчдэлд залгаж хаалгыг нээн тавиуртай дээжийг байрлуулна.
 3. Зуухны амыг хааж зохих температурыг тохируулсны дараа агааржуулагчийг ажиллуулна.
 4. Шатаах зуух ажиллах хугацааны туршид түүний ажиллагааг байнга хянана.
 5. Зуухыг хүчдэлд залгаад ажиллахгүй үед цахилгааны сүлжээ болон эд ангийг оролдохыг хориглоно.
 6. Дээж шатаж дуусаж температур багасч зуухны ам автоматаар онгойх хүртэл эд ангийг оролдохгүй хориглоно.
 7. Халуун дээжийг зориулалтын хайч ашиглан зуухнаас гаргана.
 8. Дээжийг хутгуур ашиглан тавиур дээр тараана.
 9. Шатаах зуухыг хүчдэлээс салгана.
- 6. Дайрганы марк тодорхойлох пресстэй ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа**
1. Прессийг цахилгаан хүчдэлээс салгасан эсэхийг шалгана.
 2. Ажлаа эхлэхийн өмнө ажлын хувцас, бээлий өмсөж, нүдний шил, амны хаалт зүүсэн байх шаардлагатай.
 3. Цилиндрийн дээжийг байрлуулж дээд тавцанг доош эргүүлж ойртуулсны дараа хүчдэлийг залгах
 4. Пресс шахахгүй үед цахилгаан болон өргөх шахуургыг оролдохыг хориглоно.
 5. Ажил дууссаны дараа багажыг цэвэрлэж байранд нь буцаан тавьж дараагийн туршилтанд бэлтгэж тавина.
- 7. Дайрганы цохилтын бутрагдалт тодорхойлогч багажтай ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа**
1. Ажил эхлэхийн өмнө ажлын хувцас, бээлий өмсөж амны хаалт, чихэвч, нүдний шил зүүсэн байна.
 2. Багажны түгжигчийн бүрэн бүтэн байдлыг шалгана.
 3. Хэвтэй сорьцыг багажны тавцанд сайтар бэхэлж суурилуулна.
 4. Хэвтэй сорьцыг суурилуулах болон салгаж авахдаа алх унаж гар, хөл бэртэхээс болгоомжлох хэрэгтэй.
 5. Ажлын явц дууссаны дараа алхыг аажим өргөж түгжигчийг найдвартай түгжих хэрэгтэй.
 6. Багажийг цэвэрлэж дараагийн туршилт хийхэд бэлэн болгож тавина.
- 8. CBR пресстэй ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа**
1. Хүчдэлд залгахдаа зулгуурыг нойтон гараар барьж болохгүй.

2. Прессийг тогтмол бус цахилгаан үүсгүүрт залгаж болохгүй.
3. Прессрүү ус цацгдах болон ус оруулахаас зайлсхийж ажиллана.
4. Пресс ажиллахгүй тохиолдолд задлахыг хориглоно.
5. Пресс дээр ажиллахад гэрэлтүүлэг маш сайн байх шаардлагатай.
6. Индикатор жигд гацахгүйгээр ажиллаж байх шаардлагатай.
7. Шахах сорьцыг сууринд таруулан байрлуулна.
8. Асаах товчлуурыг дарж шахаж эхлэх эсвэл бариулыг эргүүлж прессийг ажиллуулна.
9. Индикатор дээрх тоон утывг тэмдэглэж авна.
10. Хэвтэй сорьцыг пресснээс салган авч прессийг цэвэрлэнэ.
11. Прессийг хүчдэлийг унтрааж салгана.

9. Бетон хийц болон сорьцыг гулзайлгах, шахах багажтай ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1. Ажил эхлэхийн өмнө ажлын хувцас, бээлий, халад, нүдний шил, амны хаалт зүүсэн байх шаардлагатай
2. Бетоны прессэнд сорьцыг байрлуулна.
3. Шахах хүч болон хурдыг тохируулан маркыг нь зааж тохируулна
4. Ажиллуулж эхэлнэ.
5. Шахах явцад бетон үсрэхээс болгоомжлох хэрэгтэй
6. Ажил дууссаны дараа прессийг тэжээлээс салган цэвэрлэж, дараагийн туршилтанд бэлдэнэ.

10. Ширхэглэлийн бүрэлдэхүүн тодорхойлох сэгрэгч аппараттай ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1. Ажил эхлэхийн өмнө ажлын хувцас, бээлий өмсөж нүдний шил, амны хаалт зүүсэн байна.
2. Сэгрэгч аппаратыг 220 ваттын хүчдэлд залгана
3. Дээжтэй шигшүүрүүдийг сууринд байрлуулан бэхлэгчээр нь сайтар шахаж өгнө
4. Аппаратыг асаах буюу залгаж ажлын явцыг байнга хянана
5. Аппарат бүрэн зогсооны дараа дээжтэй шигшүүрүүдийг авна
6. Сэгрэгч аппаратыг цахилгаан хэлхээнээс салгаж аппаратыг цэвэрлэнэ
7. Сэгрэгч ажиллахгүй тохиолдолд цахилгаан эд ангийг оролдохыг хориглох ба мэргэжлийн хүнд хандана.

11. Асфальтбетон холигчийг төхөөрөмжтэй ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1. Холигчийн үндсэн тэжээлийг асаана.
2. Холигчийн баруун талын 1 товчийг эргүүлж ON дээр тохируулж асаана.
3. Холигчийг халаах товч 2 товчийг баруун тийш эргүүлж асаана.
4. Холигчийг температурыг 3 товчийг шалгана
5. 4 товчийг дарж холигчийг эргүүлнэ.
6. Хольж дуусмагц 5 товчийг дарж холигчийг зогсоно.
7. Холигчийн тагийг түгжээнд тултал онгойлгоно.
8. 6 товчийг баруун тийш эргүүлэхийн зэрэгцээ 7 товчийг доош нь холигчийн савны ам ажиллахад хялбар байршилд ирэх хүртэл дарна.
9. Холигчийн тогооноос хольцыг хутгуураар гаргана.

12. WT машинтай ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1. WT машины цахилгаан тэжээлийг асаана
2. Удирдлагын дэлгэцийг асаана.
3. Удирдлагын дэлгэцэн дээрх товчлуурыг дарж нууц уг /1644/-ийг оруулна. Нууц үгийг оруулахдаа удирдлыгын дэлгэцэн дээрх товчыг баруун тийш нь эргүүлж 1 гэж гарагаар товчин дээр дарж кодоо оруулна. Дэлгэцийн зүүн доод талд OK гэж гарагаар товчийг дахин дарна.
4. Ногоон товчийг дарж халаагчийг асаана.
5. Удирдлагын дэлгэцийн баруун дээд талын F1-г дарж дэлгэцийн NUMBER cycles:1440-г нягталж дахин F1-г дармагц дэлгэцийн баруун доор 1 –г гарч ирэхээр темпетарур 60°C байгааг нягталж F1-г дарж туршилтыг эхлүүлнэ.

6. Машинд сорьцыг байрлуулахдаа тэгш байгааг заавал нягтална.
7. Туршилт эхэлснээс хойш 45 мин (1100 удаа) d1-ийн өөрчлөлтийн хэмжээг тэмдэглэнэ.
8. Туршилт эхэлснээс хойш 60 мин (1400 удаа) d2-ийн өөрчлөлтийн хэмжээг тэмдэглэнэ.
9. Удирдлагын дэлгэцийг унтрааж WT машиныг цахилгаан тэжээлээс салгана.

13. Булт нягтруулагчийн ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1. Гал хамгаалагчийн шийт SW-ийг запгаж, төхөөрөмжийн асаагуурын ON товч дээр тавина.
2. LCD дэлгэцний зүүн дээд талын айкон (icon)-ыг, дараа нь Mould хэсэг дээр тус тус дарна. Үүний дараа D1-ийг шивж оруулаад, айконы голд дарна.
3. Дараагийн алхамд Roller: дээр даран, D гэж бичиж оруулаад айконы голд дарна.
4. Булт нягтруулагчийн халаагч нь 160°C –с дээш болсны дараа урд нүүрэн дэх аюулгүйн бүрхүүлийг нээж, хэвийг байрлуулж, хэв тогтоогчийг углана.
5. LCD дэлгэцэн дээрх халаагчийн температурын заалтыг нягтласны дараа айконы > дараахад 50 цохилтоор нягтруулж эхэлнэ.

14. Шатаах зуухтай ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1. Дээжийг урьдчилж халаан уярааж туршихад бэлдэнэ.
2. Дээжийг зууханд байрлуулахдаа зориулалтын саванд хийн байрлуулна. Ингэхдээ дээжний савыг хажуу талын хананд хүргэж болохгүй.
3. Багажийг цахилгаан хүчдэлд залган асаах асаах товчийг даран дэлгэцний заалт 700 градуст зааж байгаа эсэхийг нягтлан Start товчийг дарснаар зуух халж эхэлнэ.
4. Туршилт явагдаж байх явцад зуухны хаалгыг нээж болохгүй гэдгийг хатуу хориглоно.
5. Дээжийг шатаж дуусмагц мөн шууд хаалгыг нээж бологүй зуухны температур хөрөх хүртэл 2-оос 3-н цагийн дараа дээжийг зуухнаас авах шаардлагатай.
6. Туршилт дууссаны дараа дээжийг авч зуухны цахилгаан хүчдэлийг салгана.
7. Өндөр хүчдэлийн цахилгаан холболтоос болгоомжилж ажиллах
8. Хамгаалах хэрэгсэл болох нүүрэвч ханцуйвч малгай, каск халуунд тэсвэртэй бээлий зэргийг хэрэглэхгүйгээр зуухтай ажиллахыг хатуу хориглоно.
9. Удирдлагын товчлуурыг нойтон гараар ажиллуулахыг хориглоно.
10. Туршилт бүрийн дараа техник ашиглалтын паспорт дээр бичилт хийнэ.


15. Динамик даралтын реометртэй ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1. Урьдчилж дээжийг бэлтгэнэ.
2. Багажны усан ваннад байрлах шингэнийг тохирох хэмжээнд байгаа эсэхийг шалгасны дараа цахигаан хүчдэлд холбож асаах товчлуурыг тус бүр дарна.
3. Компьютерийг асааж зориулалтын программыг ачааллаж холболтуудыг бүрэн холбосон эсэхийг эсэхийг шалгана.
4. Өргөх ванны дэлгэцийг үзүүлэлтийг сайтар ашиглаж заасан температурт хүртэл хулээнэ.
5. Урьдчилж бэлтгэсэн дээжийг 2 өөр төрлийн суурин аль зохих сууринд хэвлэж зориулалтын тулхүүрээр суурьлуулан тагийг тавина. Ингэхдээ түгжигдэж байгаа эсэхийг сайтар нягтлана.
6. Туршихад бэлэн болсны дараа багжны хажууд байрлах бариулыг эргүүлж даран түгжээг ховилоос мулталсны дараа туршилтыг автомат программын тусламжтай эхлүүлэх кошиандыг өгснөөр багаж ажиллаж эхэлнэ.
7. Туршилт дууссаны дараа түгжээг зүүн тийш хувилд хийн бариулыг дээш өргөж тагийг аван сууринд наалдсан битум, дарагчид наалдсан битумыг цэвэрлэж дараагийн туршилтад бэлдэнэ.
8. Тус багажаар туршилт хийхэд лабораторийн инженер заавал байх шаардлагатай бөгөөд холболтуудыг сайтар шалгана.
9. Сорьцийг байршуулах үед болон туршилтын дараа түгжээг заавал түгжих шаардлагатай.
10. Усан ванны температурыг тогтмол шалгаж туршилтыг хийнэ.
11. Өөрийн дураар холболтуудыг салгаж нийлүүлэхийг хатуу хориглоно.

16. Холигчийг ажиллуулах дэс дараалал

1. Холигчийн үндсэн тэжээлийг асаана.
2. Холигчийн баруун талын 1 товчийг эргүүлж ON дээр тохируулж асаана.
3. Холигчийг халаах товч 2 товчийг баруун тийш эргүүлж асаана.
4. Холигчийн температурыг 3 аас шалгана.
5. 4 товчийг дарж холигчийг эргүүлнэ.
6. Хольж дуусмагц 5-ыг дарж холигчийг зогсооно.
7. Холигчийн тагийг түгжээнд тултал онгойлгоно.
8. 6 –г баруун тийш эргүүлэхийн зэрэгцээ 7-г доош нь холигчийн савны ам ажиллах хялбар байршилд ирэх хүртэл дарна.
9. Холигчийн тогооноос хольцыг хутгуураар гаргана.

...оOо...



Зам, тээврийн хөдлийн төвийн захирлын
2022 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн
.../ЧЧ/ дугаар тушаалын
батлагдсан зааварчилгаа №7

ДТД 4978 04.04.22

ЖОЛООЧ НАРЫН АЖЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

1. Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, Авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм болон стандартыг мөрдж ажиллана.
2. Өөрсдийн эзэмшиж байгаа автомашиныг цэвэрхэн нямбай эзэмшиж, бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллана.
3. Ар гэртээ сайтар амарч, согтууруулах ундаа, мансууруулах бодисын нөлөөнөөс ангид байх.
4. Автомашины тос, усны түвшин, гэрлэн дохио, толь, тоормос, резин дугуйг, биечлэн шалгана.
5. Автомашины анхааруулах гэрэл, радио станц, галын хор, эмийн сан, зогсолтын тэмдэг, нөөц дугуй, багаж тулхүүр, бусад хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгана.
6. Ажлын хувцасыг бүрэн өмсөнө.
7. Автомашины гал унтраагуурыг ашиглах чадвартай байх.
8. Жолооч нь хуваарийн дагуу ажил үүргээ гүйцэтгэх ба зөвшөөрөгдөөгүй чиглэл, заагдаагүй ажилд явах, бусдад жолоо шилжүүлэхийг хатуу хориглоно.
9. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч гарын үсэг зурсан байна.
10. Албан томилтоор явахдаа техник, аюулгүйн зааварчилгаа авч, автомашины км-ийн заалтыг машин тоног төхөөрөмжийн ашиглалт (МТТА), ХАБЭА хариуцсан мэргэжилтэнд заавал тэмдэглүүлэх.
11. Албан томилтооор явахдаа үйлчлүүлэгчийн ая тухтай байдлыг бүрэн хангаж авч яваа бичиг баримт, тоног төхөөрөмж бусад зүйлийг хамгаалж явах.
12. Хальтиргаатай, үзэгдэх орчин хязгаарлагдсан үед анхаарал болгоомжтой зорчих.
13. Авто машины засвар үйлчилгээг хийхдээ хариуцсан мэргэжилтэнд хандаж, акт бичүүлж, техникийн комиссоор шийдвэрлүүлэн, засвар үйлчилгээг хийлгэнэ.
14. Засвар үйлчилгээг хийх бүрдээ автомашины хувийн хэргийн дэвтэрт заавал тэмдэгжүүлж, гарын үсгээ зурах.
15. Засвар үйлчилгээг хийхдээ зориулалтын багаж тулхүүрийг хэрэглэхээс гадна гэмтэлтэй багаж хэрэглэхийг хориглоно.
16. Дугуйг солихдоо домкратын хажуугаар бат бөх тулгуур хийж, дугуйн хойд урд талд заавал ивээс хийнэ.
17. Мод услах, зүлэг тайрах, гадна орчны цэвэр байдлыг хангаж аиллана.
18. Осолд орсон хүнд анхны тусламж үзүүлж чаддаг байх.
19. Ажил дууссаны дараа авто машины бүрэн бүтэн байдлыг шалгаж, хариуцсан мэргэжилтэнд километрийн заалтыг тэмдэглүүлэн хүлээлгэн өгөх.

...ооо...

Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн
Аюулгүй ажиллагааны зааварчилгаа №8
батлагдсан зааварчилгаа №8
ATA 6978 01101

ХАРУУЛ ХАМГААЛАЛТ, ЖИЖҮҮРИЙН МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

1. Ар гэртээ сайтар амарч, согтууруулах ундаа, мансууруулах бодисын нелөөнөөс ангид байх.
2. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч гарын үсэг зуран, ажлын хувцасыг бүрэн ёмсөнө.
3. Гал унтраагуурыг ашиглах чадвартай байх.
4. Төвд ирсэн хүмүүсийг зөв чиглүүлж, зөв боловсон харьцах.
5. Гадны орчины цэвэр байдалд хяналт тавьж, ажилтнуудыг зөвхөн тамхи татах цэгт тамхи татах шаардлага тавих.
6. Ажлын цаг дууссаны дараа бүх өрөөний цонх, хаалга, цахилгааныг шалгаж, гэрлийг унтрааж өрөөнүүдийг түгжих.
7. Гал, ус, цахилгааны болон бусад аюулыг урьдчилан сэргийлэхэд анхаарч ялангуяа ариун цэврийн өрөө болон бусад ус алдаж, гал гарч болзошгүй газар, өрөө, хаалга, цонх бүрэн эсэхийг байнга шалгана.
8. Халаалттай үед бүх өрөөний халаалтыг байнга хянан, ус алдаж хөлдсөн байгаа эсэхэд анхаарал тавьж ажиллах.
9. Цахилгаан тасарсан үед ажиллаж байсан тоног төхөөрөмжийг унтраана. Тэсэж дэлбэрэх бодис, бинзенийг ажлын байранд хадгалахгүй байх.
10. Телефон утас, хяналтын камерын найдвартай ажиллагааг хянан, ажилтнуудаар камериин бичлэг үзүүлж, ухраахыг хатуу хориглоно. Камер ажиллахгүй байгаа тохиолдолд мэдээлийн технологи хариуцсан мэргэжилтэнд цаг тухайд нь мэдэгдэх.
11. Ажлын цагаар авто зогсоол дээр байгаа автомашинуудад хяналт тавьж, хэзээ ямар машин хэн авч гарсан, ирснийг рапортын дэвтэрт бүртгэнэ.
12. Усны ваннд ус татахдаа татаж дуустал нь хажууд нь байна. /Жижүүрээс өөр хүн ус татахыг хориглоно/
13. Ажлын байранд пиво, архи хэрэглэхийг хатуу хориглоно.
14. Мод услах, зүлэг тайрах, зэрлэг өвс түүх зэрэг гадна орчины цэвэр байдлыг ханган ажиллах.
15. Хог ачуулах, бохир соруулахад хамт байж "Жижүүрийн дэвтэр"-т хөтөлж байх.
16. Осол гамшиг, дулаан, ус хангамжийн доголдол гарсан тохиолдолд шуурхай арга хэмжээг авч, холбогдох мэргэжилтэн, албан тушаалтанд мэдэгдэх.
17. Амралтын өдрүүдэд болон ажилын цаг дууссаны дараа гадны хүн оруулахыг хатуу хориглоно.
18. Ажилтан бүр ажил үүргээ биелүүлэх явцад аюулгүй ажиллагааны нөхцөл зөрчигдеж хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг, аюултай байдал бий болсон тохиолдолд ажлаа нэн даруй зогсоож, энэ талаар удирдлагадаа яаралтай мэдэгдэнэ.
19. Ээлж хүлээлцэх бүрт дараагийн ээлжийн ажилтан /жижүүр/-д төвийн бүрэн бүтэн байдлыг нэг бүрчлэн хүлээлгэн өгч "Жижүүрийн дэвтэр"-т тэмдэглэл хөтөлнө.

...оо..

Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн
АУЧИЛГААР ТУШААЛЫН ХАВСРАЛТААР
батлагдсан зааварчилгаа №9

АТД 4975 №9

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

1. Ар гэртээ сайтар амарч, согтууруулах ундаа, мансууруулах бодисын нөлөөнөөс ангид байх.
2. Ажлын халад, бээлийг бүрэн өмсөнө.
3. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа ХАБЭА хариуцсан мэргэжилтнээс авч гарын үсэг зурах.
4. Гал унтраагуурыг ашиглах чадвартай байх.
5. Төвийн болон гадны хүмүүстэй зөв боловсон харьцах.
6. Хариуцсан өрөө, тасалгааны цэвэрлэгээг тогтмол хийж, агаар сэлгэлтийг тогтмол хийж байх.
7. Өрөөний цэвэрлэгээг хийх явцад тоног төхөөрөмж, эд хөрөнгөд анхаарал болгоомжтой хандах.
8. Ариутгалын бодисын ангилал зориулалтыг зөв хэмжээгээр нь хэрэглэдэг байх.
9. Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээг тогтмол хийж, байнгын хараа хяналттай ажиллах.
10. Хана таазны шороог буулгаж цэвэрлэхдээ шат хэрэглэн аюулгүй ажиллагааг хангасан байна.
11. Өрөөнүүдийн паар болон цонхыг сард 1-2 удаа арчиж цэвэрлэх.
12. Утас, залгуур, цахилгааны холболттой болгоомжтой харьцаж, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах.
13. Төвөөс зохион байгуулж байгаа аливаа сургалт, олон нийтийн арга хэмжээнд бүрэн хамрагдах.
14. Ажилтан бүр ажил үүргээ биелүүлэх явцад аюулгүй ажиллагааны нөхцөл зөрчигдэж хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг, аюултай байдал бий болсон тохиолдолд ажлаа нэн даруй зогсоож, нэн талаар удирдлагадаа яаралтай мэдэгдэнэ.
15. Цэвэрлэгээний хувин, шүүр, алчууд, тосгуур, шалны мод гэх мэт цэвэрлэгээний багаж хэрэгслийг заасан цэгт эмх цэгтэй байрлуулна. Алчуурыг зориулалтаар нь ангилан тэмдэгжүүлнэ.

...оо...

Зам, тээврүүн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн
А/Ц дугаар тушаалтын хавсралтаар
батлагдсан зааварчилгаа №10

ATA4973-0111

ӨНДӨРТ АЖИЛЛАХ ҮЕЙИН АЮУЛГҮЙН АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

1. Өндөрт хийгдэх ажлуудыг зөөврийн модон шат буюу найдвартай байрлуулсан тавцан дээрээс гүйцэтгэнэ
2. 1,2 метрээс 5 метр хүртэл өндөрт шал, хашлагатай талбай дээр ажил гүйцэтгэх үед түшүүлдэг зөөврийн шат ба хамгаалах бусийг хэрэглэнэ.
3. Шатны дээд үзүүр нь бэхбат тулгуурт тулж байхаар байрлаж, өгсөж уруудаадаа гартаа багаж хэрэгсэл барьж болохгүй./багаж хэрэгсэлийг олс татлагаар буюу цүнхэнд хийж мөрөндөө бэхлэн үүрч өгсөж уруудах/
4. Шатыг гулсахаас болгоомжлон үзүүрт нь төмөр хошуу (газар буюу модон шалан дээр ашиглах үед), резин жийргэвч (цутгамал, металл, чулуун шалан дээр ашиглах үед) байгааг шалгах.
5. Эвдэрхий, эсвэл туршилт хийгдээгүй шат / гишгүүр хажуу тал нь цуурсан, хугарсан мэн хажуу талыг нь цоолж гишгүүрийг углуургадаагүй / хоёр хажууг нь холбож хадсан гэх мэт/ шатыг ашиглахыг хориглоно.
6. Хамгаалах бусийг хэрэглэхийн өмнө түүний бүрэн бүтэн байдал, туршилтын хугацаа хэтэрсэн эсэхийг шалгана. Хамгаалалтын бусийг жилд нэг удаа туршиж шалгана.
7. Зөөврийн түшүүлдэг шат 6 сард 1 удаа туршигдсан байна. Шатан дээр дараагийн турших хугацааг заасан бирк байдаг.
8. Барилгын угсардаг шат, давцан, талбай нь: бат бөх, хөдөлгөөнгүй байх
9. Өндөрт ажиллах зорилгоор барилгын угсардаг шат, давцан болон эдгээртэй төстэй тоноглолтыг ашиглахдаа доор нь ажиглагч томилох ба орчинд нь аюулгүй ажиллагааны бус тогтоож анхааруулах тэмдэг өлгөнө.
10. Угсардаг шатан дээрээс багаж хэрэгсэл, материал бусад зүйлийг хаяхыг хориглоно. Тэдгээрийг доош унагаахгүй байрлуулна.
11. Багаж хэрэгсэл, материалыг угсардаг шатан дээр гарган дээрээс буулгахдаа зориулалтын саванд хийж олс ашиглан гүйцэтгэнэ.
12. Шал, давцан, угсардаг шатны талбайгаас дээш 5м өндөрт хийх ажил өндөрт гүйцэтгэх ажилд хамаарна.

...оо...

Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн
.../44 дугаар тушаалтын хавсралтаар
батлагдсан зааварчилгаа №11

АТДАЧИЛГААНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

1. Аливаа цахилгаан хэрэгсэлтэй харьцахын өмнө заавар, гарын авлагыг уншиж танилцах. Зааврыг ойлгоогүй бол мэргэжлийн хүнээс туслалцаа авах /таамгаар ажиллахыг бүү оролд/.
2. Ажилтан бүр ажил үүргээ биелүүлэх явцад аюулгүй ажиллагааны нөхцөл зөрчигдэж хүний амь нас, эрүүл мэндэд, сөрөг аюултай байдал бий болсон тохиолдолд ажлаа нэн даруй зогсоож, энэ талаар удирдлагадаа яаралтай мэдэгдэх үүрэгтэй.
3. Багаж ажиллаж байх үед цахилгааны утсыг нугалах, мушгих, дээр нь хүнд зүйл тавихыг хатуу хориглоно.
4. Цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмжийг эх үүсвэрээс салгахдаа утаснаас зуурч татаж болохгүй, харин сэрээний бариулаас барьж татахыг анхаарах.
5. Багажны тэжээлийн утас ба кабелийг халуун, нойтон ба тостой гадаргуу болон биеттэй шууд шүргэлцэн хүргэхгүй байх.
6. Цахилгаан багаж ба зөөврийн цахилгаан машин ашиглаж байгаа хүмүүст:
 - Түр хугацаагаар боловч тэдгээрийг бусад хүмүүст дамжуулан хэрэглүүлэх
 - Тэдгээрийг задалж өөрөө ямар нэгэн засвар хийх
 - Цахилгаан багажны утаснаас барих, багажны эргэлдэн зүсэх хэсэгт хүрэх
 - Машин бүрэн зогсоохос өмнө ажиллаж байх үед үрдэс зоргодосыг гараар зайлуулах
 - Төмөр тонон төхөөрөмж хадгалах сав зэргийн дотор зөөврийн трансформатор болон давтамж хувиргагчийг зөөж оруулах
 - Зөөврийн цахилгаан машин, багажийг цахилгаан сүлжээнд залгаатай нь болон хараа хяналтгүй орхих зэргийг тус тус хориглоно.
7. Цахилгаан хөрөө, точил, өрөм дээр ажиллахын өмнө эргэлтээр ажилладаг ажлын хэсгийн чангалаа, эргэж байгаа эд ангитай харьцах хэсгийн бүрэн бүтэн байдлыг заавал шалгаж байна.
8. Гар багажнуудыг ажил дуусах болон бусдад шилжүүлэхдээ бүрэн унтрааж, эргэлт зогсооны дараа өгөх буюу тавиур дээр тавина.
9. Цахилгаан гүйдлийн нөлөөнд өртсөн осолдогчийг хүчдэлээс чөлөөлөх, түүнд анхны тусламж үзүүлэх арга барил эзэмшсэн байна.
10. Гал унтраагуурыг ашиглаж чаддаг байх, тоног төхөөрөмж, техникийн мэдлэгтэй байх.
11. Тэсэрч дэлбэрэх бодис, бензинийг ажлын байранд хадгалахгүй байх.
12. Ажил гүйцэтгэж дууссаны дараа ажлын байрыг эмхэлж цэгцлэн багаж хэрэгслийг зориулалтын тавиур тавих.
13. Гал гарсан үед 101 утсаар Обхэлтэст нэн даруй мэдэгдэх (энэ үед гал гарсан байрлал, мөн өөрийн овог нэрийг зайлшгүй мэдээлэх шаардлагатай)

...ооо...

Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 04 дүгээр сарын №12-ний өдрийн
А/Д дугаар тушаалтын хавсралтаар
батлагдсан зааварчилгаа №12

АТДСОТЫН ТӨВИЙН ЗАХИРЛЫН

ТӨЛБӨР АВАХ ЦЭГИЙН АЖИЛТНУУДЫН МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

1. Ахлах болон төлбөр хураагч нар нь ажил үүргээ гүйцэтгэхдээ хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаанд тусгагдсан зааврыг мөрдөн ажиллана.
2. Төлбөр авах цэгийн ахлах нь төлбөр хураагч, авто пүүний оператор нарыг ээлж солилцоход өөрийн биеэр байлцан ХАБЭА-н зааварчилгааг өгөх, ХАБЭА-н “Ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгаа”-ны бүртгэлийн дэвтэрт төлбөр хураагч нарын гарын үсгийг зуруулан баталгаажуулах.
3. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, журамтай танилцаж зохих мэдлэгтэй болох
4. Байгалийн гамшиг, гэнэтийн аюул ослоос өөрсдийгөө хамгаалах дадал эзэмших
5. Гэнэтийн халдлага, аюулаас өөрийгөө хамгаалах, камер ажиллаж байгааг зорчигч болон жолооч нарт байнга сануулж зөв боловсон харьцаж хууль тогтоомж, тушаал зааврыг зөв танилцуулж ойлгуулах
6. Яаралтай үед холбогдох утасны жагсаалтуудыг ТАЦ-ийн мэдээллийн самбарт байрлуулах ТАЦ-н ахлах нар нь холбогдох утсыг байнгын нээлттэй байлгах
7. Ажлын байран дахь багаж, тоног төхөөрөмжийг зөв ажиллуулах ажлын хувцсыг тогтмол цэвэр нямбай өмсөх, орчны ариун цэврийг тогтмол сахих
8. Төлбөр авах цэгийн ажилчид ахлахын удирдлага дор сард 1-2 удаа төлбөр авах цэгийн гадна дотно орчинд үзлэг шалгалт хийн гарж болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх
9. Үзэгдэх орчин хязгаарлагдмал нөхцөлд машины урдуур явах гүйхийг хориглоно. Машины урдуур зайлшгүй гарах тохиолдол бүрд авто машины жолоочид урьдчилан мэдэгдэж анхааруулга өгөх.
10. Гаднах гэрэлтүүлгийг шөнө байнга асааж байх, хэрэв ажиллахгүй гэмтсэн шатсан бол ТАЦ-н ахлагчид мэдэгдэн яаралтай засварлах
11. Цахилгаан хэрэгсэл разетка, унтраалга цахилгааны самбар, цахилгаан тоолуур зурагт компьютер дур мэдэн оролдох засахгүй байх
12. Тэсэрч дэлбэрэх бодис, тос тосол. бензин, шатамхай материал зэргийг ажлын байранд хадгалахгүй байх.
13. Ажлын байранд архидах согтууруулах ундаа хэрэглэх, гадны хүмүүс оруулахыг хатуу хориглоно.
14. Пийшин галлагаатай үед байнга хараа хяналт тавьж, зуухны амыг хааж түгжих байх.
15. Халаагуурыг ашиглахдаа ханаас хол байлгах, разетка залгуурыг халах хайлах зэрэг эрсдэлээс сэргийлэн хянах, хэрэглэж дуусаад унтраах,
16. Автомат хаалт, хашлага, зөөврийн түмбэ, гэрэл, багаж, ТАЦ, пүүний байр, эд хогшил, тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдалыг шалган өдөр бүр хүлээнцэх
17. Төлбөр авагч өөрийн буруутай үйлдлээс болж замын хашлага, түмбэ, гэрэл, хаалт, багаж тоног төхөөрөмж, зорчигчийн тээврийн хэрэгсэл эд хөрөнгийг эвдэж үрэгдүүлсэн бол шинээр авах, хохиролыг барагдуулах.

18. Цас орсон тухай бүрд ТАЦ-н эргэн тойрон замын цасыг малтаж овоолон халтиргаа гулгаанаас сэргийлэх
19. Гулгаа халтиргаатай үед халтиргаа гулгааг арилгах, багасгах, гулгаанаас сэргийлэхээр бодис, хайрга, элс, давс асгаж яаралтай сэргийлэх арга хэмжээ авах
20. Жолооны буруу хүрдтэй машины жолоочоос дамжуулж авах хүн байхгүй бол гадагшаа гарч төлбөрийг авах Гадагш гарахын өмнө жолоочид заавал сануулан хэлэх
21. Том оврын өргөн ачаатай машины жолооч нарт анхааруулга өгч болгоомжтой нэвтрэхийг зөвлөж хамтарч ажиллах
22. Өргөн ачаатай трайлер , тээврийн хэрэгслийг туслах замаар нэвтрүүлэх
23. Төлбөр авах цэгийн дотор, гадна орчин тойрны цэвэрлэгээг тогтмол өглөө бүр цэвэрлэж хүлээлгэн өгөх . Ажиллах явцдаа ажилтан өөрийн хувийн ариун цэврийг сайтар хангах
24. Төлбөр авах цэгт байрлуулсан анхны тусlamжийн эмийн сан дахь эм, ариутгалын бодис, ариун бинт зэргийн хадгалах хугацаа галын хорын ашиглалтын хугацаанд хяналт тавих
25. ТАЦ-т байрлуулсан галын саравч доторх багаж гал унтраах хэрэгслийн бүрдлийг хангах, бүрэн бүтэн байдалд хяналт тавих
26. Ажилтан бүр ажил үүргээ биелүүлэх явцад аюулгүй ажиллагааны нөхцөл зөрчигдэж хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг, аюултай байдал бий болсон тохиолдолд ажлаа нэн даруй зогсоож энэ талаар удирдлагадаа яаралтай мэдэгдэх үүрэгтэй

...ооо...


Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 04 дугаар сарын 18.-ний өдрийн
17/11 дугаар 18 тушаалтын хавсралтаар
батлагдсан зааварчилгаа №13

ДТД4978 00000000000000000000000000000000

ХЯНАЛТЫН ИНЖЕНЕРИЙН МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

- Хөдөө орон нутагт ажиллахаар явахдаа ХАБЭА-н аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч ажиллах.
- Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ ажил гүйцэтгэхийг хориглоно.
- Ажлын талбайд ажлын хувцас хэрэгслийг (инженер техникийн хувцас, дуулга (каск) нүдний хамгаалалтын шил, хуруу, шагайны зориулалтын дагуу өмсөж хэрэглэх, зөвхөн ажил гүйцэтгэх үед өмсөнө.
- Ажлын талбай дээр заах, хориглох, анхааруулах болон бусад шаардлагатай тэмдэг тэмдэглэгээг тавьж ажиллах.
- Өөрсдийн эзэмшиж байгаа багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж эвдэрсэн бол нөхөн төлж удирдлагад мэдэгдэх.
- Гүүрэн дээр ажиллах үед болон 1,2 метрээс дээш өндөрт гарч ажиллахдаа өндрийн хамгалалтын бус, шатыг тогтмол хэрэглэнэ.
- Гүүрэн дээр ажиллах үед усны түвшин их байвал аврах хантааз өмсөж зориулалтын завь ашииглаж байх.
- Өндөр хүчдэл, цахилгааны аюулгүй байдлыг хангаж, хаалт, хамгаалалт газардуулгыг хийсэн байна.
- Ажилд гаражын өмнө ажилтнуудад ХАБЭА-н зааварчилгаа өгч гарын үсэг зуруулан ажилд гаргана.
- Гүүр, хоолойны барилга угсралтын ажлын үед хамгааалалтын дуулга (каск), өндрийн бус хөдөлмөр хамгааллын хувцастай ажиллах.
- Битум болон химийн хортой бодисын нөхцөлд ажиллахдаа хамгаалах хэрэгсэл маск, хошуувчийг хэрэглэнэ.
- Анхны тусlamжийн жижиг эмийн сангийн бүрдлийг биедээ авч явах.
- Шөнө ажиллах үедээ гэрэл ойлгогчтой ажлын хувцас өмсөж, гэрэлтүүлэгтэй ажиллах.
- Ажилтан бүр ажил үүргээ биелүүлэх явцад аюулгүй ажиллагааны нөхцөл зөрчигдэж хүний ам нас, эрүүл мэнд сөрөг, аюулгүй байдал бий болсон тохиолдолд ажлаа нэн даруй зогсоож, энэ талаар удирдлагадаа яаралтай мэдэгдэх үүрэгтэй.
- Гал гарсан үед 101 утсаар ОБхэлтэст нэн даруй мэдэгдэх (энэ үед гал гарсан байрлал, мөн өөрийн овог нэрийг зайлшгүй мэдээлэх шаардлагатай)


...ооо...



ХӨДӨЛГӨӨНТ ЭРГҮҮЛИЙН АЖЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

1. Авто замын тухай хууль, Захирлын баталсан 2018 оны А/54 "Хөдөлгөөний эргүүл ажиллуулах журам"-ыг баримтлан ажиллах,
2. Ар гэртээ сайтар амарч, согтууруулах ундаа, мансууруулах бодисын нэлөөнөөс ангид байх.
3. Өөрсдийн хариуцаж байгаа багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах.
4. Автомашины тос, усны түвшин, гэрлэн дохио, толь, тоормос, резин дугуйг, биечлэн шалгана.
5. Автомашины анхааруулах гэрэл, радио станц, галын хор, эмийн сан, зогсолтын тэмдэг, нөөц дугуй, багаж түлхүүр, бусад хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгана.
6. Ажлын талбайд ажлын хувцас хэрэгслийг (инженер техникийн хувцас, дуулга (каск) нүдний хамгаалалтын шил, хуруу, шагайны)зориулалтын дагуу өмсөж хэрэглэж, зөвхөн ажил гүйцэтгэх үед өмсөнө.
7. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч гарын үсэг зурсан байна.
8. Тээврийн хэрэгслийн жолооч нартай зөв боловсон харьцах.
9. Авто машины засвар үйлчилгээг хийхдээ хариуцсан мэргэжилтэнд хандаж, акт бичүүлж, техникийн комиссоор шийдвэрлүүлэн, засвар үйлчилгээг хийлгэнэ.
10. Дугуйг солилхдоо демократын хажуугаар бат бөх тулгуур хийж, дугуйн хойд урд талд заавал ивээс хийнэ.
11. Ажилтан бүр ажил үүргээ биелүүлэх явцад аюулгүй ажиллагааны нөхцөл зөрчигдэж хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг, аюултай байдал бий болсон тохиолдолд ажлаа нэн даруй зогсоож, энэ талаар удирдлагадаа яаралтай мэдэгдэнэ.
12. Ажил дууссаны дараа авто машин, багаж тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалгаж хадгалалтын нөхцөлийг хангана.

...ооо...



Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн
14 дугаар тушаалын хавсралтаар
батлагдсан зааварчилгаа №15

ATA4578

**ЗӨӨВРИЙН АВТО ПҮҮГЭЭР АЖИЛЛАХ ҮЕИЙН
ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН АЮУЛГҮЙ
АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА**

1. Ажилтан ажил гүйцэтгэхийн өмнө тухайн ажлыг осол авааргүй гүйцэтгэх техникийн заавартай танилцах
2. Ажилтан үүрэгт ажлаа гүйцэтгэхээс өмнө аюулгүй ажиллах бүх нөхцөлийг бүрэн хангаж гэрэл ойлгогчтой ажлын хувцас, хамгаалалтын малгай, гутлыг бүрэн өмсөж шаардагдах багаж хэрэгслийд бүрэн эсэхийг шалгана.
3. Бат бэх чанартай жинлэгч тавцанг тэгш гадаргуу дээр байрлуулах /налуу болон уруу гадаргуу дээр байрлуулахгүй/
4. Зөөврийн гэрэл ойлгогчтой түмбийг жинлэгч тавцан байрлуулсан талыг хааж 3 метрийн зйтай 7-8 ширхгийг байрлуулсан байх
5. Ажилтан ажлыг эхлэхийн өмнө ажлын орчин тойрон зам талбайг шалган ажлыг эхлүүлнэ
6. Тээврийн хэрэгслийг авто пүү нь дээр байрлуулж зогсоох ажилтан цацууллагчтай дохиураар тээврийн хэрэгсэлд чиглэл өгнө.

...ооо...

Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 04 дүгээр сарын 18...-ний өдрийн
18 дугаар тушаалтын хавсралтаар
батлагдсан Зааварчилгаа №16

ATA 1973 9021 0001

ТЕХНИК АШИГЛАЛТЫН ТҮВШИН ТӨГТООХ АЖЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЗААВАРЧИЛГАА

1. Томилолтоор явахаас өмнө ХАБЭА хариуцсан мэргэжилтнээс аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч гарын үсэг зурсан байна.
2. Өөрсдийн хариуцаж байгаа багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах, ажил эхлэхийг өмнө эд ангийг шалгаж гэмтсэн тохиолдолд хэмжилт хийхгүй байх.
3. Ажлын талбайд ажлын хувцас хэрэгслийг зориулалтын дагуу өмсөж, автомашины анхааруулах гэрэл, зогсолтын тэмдгийг байршуулж, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалган ажлыг эхлүүлнэ.
4. Ажлын талбайд хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж заах, хориглох, анхааруулах болон бусад шшардлагатай тэмдэг тэмдэглэгээг тавьж ажиллах.
5. Автомашины гал унтраагуурыг ашиглах чадвартай байх.
6. "MNS 6441:2014 Авто зам, замын байгууламжийн техник ашиглалтын түвшин тогтоох ажлын аргачлалын 3.2.1 дэхь заалтыг баримтлан ажиллах.
7. Цахилгаан утас сүлдсан байх, ил шалбарч гарсан байх, зэрэгээс болгоомжлон, гэмтлийг тухай бүрт нь арилгах.
8. Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй ажиллах техникийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллана.
9. Журамд заасан улирал цаг уурын хуваарийн дагуу ажиллах.
10. Талбайд ажиллах үед үйлчилгээний машинаас бууж, суухдаа унах, халтирах гар хөлөө машины хаалганд хавчуулхаас болгоомжлох.
11. Багаж тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийхдээ удирдах албан тушаалтан, нягтлан бодогчид хандаж шийдвэрлүүлэн, засвар үйлчилгээг хийлгэнэ.
12. Ажилтан бүр ажил үүргээ биелүүлэх явцад аюулгүй ажиллагааны нөхцөл зөрчигдэж хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг, аюултай байдал бий болсон тохиолдолд ажлаа нэн даруй зогсоож, энэ талаар удирдлагадаа яаралтай мэдэгдэнэ.
13. Ажил дууссаны дараа багаж тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалгаж хадгалалтын нөхцлийг хангана.

...оо...

Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 04 дүгээр сарын 19...-ний өдрийн
A/11 дугаар тушаалын хавсралтаар
батлагдсан зааварчилгаа №17

ДТАДФТД ОРСОН ТУШААЛЫН

ТАТТ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАГАЖ ХЭРЭГСЭЛТЭЙ АЖИЛЛАХ ТЕХНИК АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

- CS9300 Зөөврийн тэгш бус байдлын системтэй ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа**
 - Ажилтан ажлыг гүйцэтгэхээс өмнө тухайн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй ажиллах аюулгүй ажиллагааны заавартай танилцсан байх.
 - Багаж тоног төхөөрөмжийг авто машины урд хэсэгт сайтар холбож байруулах.
 - Авто машинтай холбогдох цахилгааны утас, тэжээл, бусад бэхэлгээг сайтар шалгаж холбоно.
 - Авто машины бүрэн бүтэн байдал, гэрэл, дугуйны хий зэргийг шалгах.
 - Хэмжилт хийхдээ авто зам дээрх хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж аваарын гэрэл / дуут болон гэрлэн дохио/-г ажиллуулах.
 - Хэмжилт хийх авто замын эхлэлийн цэг, дуусах цэг, замын чиглэл зэргийг сайтар бичиж тэмдэглэх.
 - Тэгш бус байдлын хэмжилтийг агаарын хэм -C⁰ орсон болон цас бороотой үед хийхгүй байх.
 - Хэмжилтийн ажил дуусаад багаж тоног төхөөрөмжийг шалган хураана.
- Cooper-Wessex дүүжин халтиргаа хэмжигч дээр ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа**
 - Ажилтан ажлыг гүйцэтгэхээс өмнө тухайн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй ажиллах аюулгүй ажиллагааны заавартай танилцсан байх.
 - Ажил эхлэхийн өмнө ажлын хувцас, хэрэгслийг бүрэн өмсөх.
 - Хэмжилт хийхдээ авто зам дээрх хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж, анхааруулах тэмдэг /түмбэ/-ийг бүрэн гүйцэд байрлуулсны дараа ажлыг эхлэх.
 - Багаж тоног төхөөрөмжийг бүрэн гүйцэд угсарч, туслах материалыг бэлтгэх.
 - Хэмжилт хийх цэг дээр багажийг зөв тэгш хэмд байрлуулах.
 - Хэмжилтийн ажил дуусаад багаж тоног төхөөрөмжийг шалгаж хураана.
- Асфальтбетон хүчилтаас дээж авах өрмийн машинтай ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа**
 - Ажилтан ажлыг гүйцэтгэхээс өмнө тухайн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй ажиллах аюулгүй ажиллагааны заавартай танилцсан байх.
 - Ажилтан ажлаа гүйцэтгэхийн өмнө хамгаалалтын хувцас, малгай гутал болон шаардлагатай техник хэрэгслүүд, ажлын багаж бүрэн байгааг шалгасан байх.
 - Ажил эхлэхийн өмнө хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, анхааруулах тэмдэг /түмбэ/-ийг 50-100 метрт байрлуулах.
 - Багаж тоног төхөөрөмжийг цахилгаанд залгаж салгахдаа хуурай гараар барьж залгаж салгах, цахилгаан дамжуулах утас шалбарч гэмтсэн эсэх цахилгаан үүсгүүрийн бүрэн бүтэн байдлыг шалгах.
 - Суурьтай яндан өрмийг тэгш хэмд байрлуулж сайтар дарж, жигд хэмээр хөрөөдөх.
 - Багажтай ажиллах явцад гар утас болон чихэвчний хөгжим сонсох, өөр бусдаар анхаарлаа сарниулахгүй байх.
 - Ажлын үеэр анхааралтай байж хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагуудыг зөрчихгүй байх.
- Динамик шигдэлтийн аргаар DCP /Dynamic ConePenetration/ авто замын далан, суурын даацыг хэмжих багажтай ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа**
 - Ажилтан ажлыг гүйцэтгэхээс өмнө тухайн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй ажиллах аюулгүй ажиллагааны заавартай танилцсан байх.
 - Ажилтан ажлаа гүйцэтгэхийн өмнө хамгаалалтын хувцас, малгай гутал болон шаардлагатай техник хэрэгслүүд, ажлын багаж бүрэн байгааг шалгасан байх.

3. Ажил эхлэхийн өмнө хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, анхааруулах тэмдэг /түмбэ/-ийг 50-100 метрт байрлуулах.
 4. Багажийг угсрах болон тайлах явцад алх болон гол төмөр унаж гар хөлөө гэмтээхээс сэргийлэх.
 5. Хэмжилт хийх явцад алхтай болгоомжтой ажиллах. Өөрийн болон бусдын гар хөлийг хавчуулахаас сэргийлэх.
 6. Авто замын даланд шигдэж орсон гадсыг сугалахдаа зөв техниктэй, аюулгүй байдлыг хангаж ажиллах.
 7. Багажаар нэг цэгээс нөгөө цэгт хэмжилт хийхдээ тус багажны хошуу, гол төмөр, дундын бул, бариулын суларсан эсэхийг сайтар шалгах.
 8. Багажтай ажиллах явцад гар утас болон чихэвчний хөгжим сонсох, өөр бусдаар анхаарлаа сарниулахгүй байх.
 9. Зөөж тээвэрлэх үед зориулалтын сав хайрцганд хийж унаж эвдхээргүй байдлаар авч явна.
5. **Асфальтбетон хучилтын гадаргуун барзгаржилт, дугуйн мөрний ховил, авто замын хөндлөн огтлол геометр хэмжилт, авто замын тэмдэг тэмдэглэгээ, хиймэл байгууламжийн үзлэг хийх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа**
1. Ажилтан ажлыг гүйцэтгэхээс өмнө тухайн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй ажиллах аюулгүй ажиллагааны заавартай танилцсан байх.
 2. Ажилтан ажлаа гүйцэтгэхийн өмнө хөдөлмөр хамгаалалтын хувцас, каск, гутал зэргийг бүрэн өмсөх.
 3. Ажлын багаж тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалгасан байх.
 4. Ажил эхлэхийн өмнө хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, анхааруулах тэмдэг /түмбэ/-ийг 50-100 метрт байрлуулах.
 5. Хөдөлгөөний эрчим ихтэй авто замд эсрэг урсгалд хэмжилт хийх үед анхаарал болгоомжтой байж, зайлшгүй тохиолдолд хөдөлгөөнийг түр хязгаарлах шаардлагатай.
 6. Өндөр далантай авто замын хажуу налуу, гүүр, хоолойд үзлэг хийхдээ хальтрах, усанд унах зэргээс сэргийлэх хэрэгтэй.
6. **ROMDAS СИСТЕМИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА**
- Ерөнхий удирдамж

LRMS/LCMS эсвэл лазер профиль гэх мэт 3В ангиллын лазерын төхөөрөмжөөс ялгарах лазерын цацрагт өртөх нь хүний нүд арьсанд аюултай. Ялангуяа лазерын ойролцоо байх үед нүд өртөх хугацаа нь хэдхэн секундээр хэмжигдэх аюултай. Энгийн нүдээр харахад лазерын цацраг ялгарч байгаа нь харагддаг. Харин харагдахгүй байгаа бол лазерт санамсаргүй өртөх ба түүний улмаас нүд гэмтэх эрсдэл нэмэгддэг. Та LRMS/LCMS-ийн лазерын аюулгүй байдлын талаар мэдэх ёстой бөгөөд эдгээр аюулгүй ажиллагааны талаар мэдлэгүй хүн LCMS системийг ашиглах нь аюултай.

Энэхүү тэмдэг нь лазерын цацрагийн аюултай болохыг илтгэнэ. Та эдгээр тэмдгүүдийг бүх ROMDAS лазер төхөөрөмж дээрээс харах болно.

- Лазер төхөөрөмж дээр (LRMS/LCMS/Laser Profiler)
- Лазер хянагчийг идэвэхжүүлэх түлхүүр дээр
- Автомашин дээр байж болно.

Лазерын нөлөөллийн түвшин хүний нүдэнд аюулгүй байх түвшнээс давсан гурван хэмжээст бусийг N.OHD буюу "Нүдэнд аюултай нөлөөллийн нэрлэсэн бүс" гэж нэрлэдэг. Лазерын хяналтын бүс нь лазерын төхөөрөмжтэй холбоотой бөгөөд нүдэнд аюултай нөлөөллийн нэрлэсэн бусийг хэлнэ. Та лазерын хамааралтай бүсэд байх шаардлагатай бол лазерын хамгаалалтын шил заавал зүүх ёстой.

3В ангиллын лазерын төхөөрөмжийг ажиллуулахад аюулгүй байдлын эрсдэл үүсч болзошгүй тул лазер систем ашигладаг байгууллагуудад лазерын аюулгүй байдлыг хариуцсан ажилтанг томилоно.

Лазерын тоног төхөөрөмж дээр ажиллах ажилтан нь өдөр тутмын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана. Ажилтан нь лазерын аюулгүй байдлын зохих дүрэм журмыг мөрдүүлэх, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны хяналтыг зохих арга хэмжээг бий болгох үүрэгтэй. ROMDAS лазер төхөөрөмж нь ROMDAS-ын төв системээс тэжээгддэг боловч зөвхөн лазер түлхүүр асаалтай үед лазерын туяаг ялгаруулдаг. Лазер профилометрийг ашиглаагүй үед түлхүүрийг нь салгаж авах шаардлагатай.

ROMDAS Лазерын аюулгүй байдлын тусгай түлхүүр

Лазер нэгж дээр ил харагдах LED анхааруулга

- Лазер төхөөрөмж бүр дээр (TPL-ээс бусад) лазер туяа идэвтэй байгааг анхааруулсан операторт харагдахуйц байрлалтай улаан LED гэрэл бүхий анхааруулах дохиолол бий.

ROMDAS Controller –ийн түлхүүртэй унтраалга

- Лазер профилометрийг ROMDAS Controller-ooc удирдаж ажиллуулдаг. ROMDAS Controller нь түлхүүртэй унтраалгаар түгжиж болдог.

Автомашиныг урьдчилан тохируулсан идэвхижүүлэх хурдаар хөдлөхгүй л бол бага хурдны аюулгүй байдлын түгжээ нь лазерыг идэвхжүүлэхийг зогсоно. PIR мэдрэгч LRMS/LCMS-ийн лазер мэдрэгчийн ойролцоо ямар нэг хөдөлгөөн илэрсэн үед лазерыг болон тестийн товчлуурыг идэвхгүй болгоно. Тээврийн хэрэгсэл хөдөлж байх үед лазерын нөлөөгөөр аюулгүй байдлын эрсдэл гарах магадлал маш бага бөгөөд хөдөлж буй тээврийн хэрэгслийн ердийн хэмжилтийн нөхцөлд эрсдэлийн менежмент шаардлагагүй.

...оОо...

7. Гадаргуун боловсруулалтын /slurry seal/ авто машины операторын ажлын үед өгөх аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Гүйцэтгэх ажил:

Асфальтбетон хучилтанд элэгдлийн үе хийх

Ажилд гарахын өмнө:

1. Ажлын байранд АМХ-р эрсдэлийн үнэлгээ хий.
2. Автомашинд суух, буухдаа машин руу нүүрээ харуулан турван цэгийн тулгуурын зарчмыг баримтлах
3. Машиныг асаахаас өмнө /унтраасан үед/ үзлэгийг хийнэ. Үүнд:
 - Автомашины хөдөлгүүр, дамжуулах эд анги, явах эд анги /хяналтын систем, хөдөлгүүр, бункер, халаагч, агааржуулалт, ширшигч/ зэргийн бүрэн бүтэн байдлыг шалгах
 - Түлш хүртээмжтэй эсэхийг шалгах
 - Салхины болон бусад шилний харагдах байдал, цууралт зэргийг шалгах
 - Автомашины дугуйн хийн даралт хэвийн эсэхийг шалгах
 - Хянах самбарын ажиллагаа
 - Шил арчигч, дуут дохионы ажиллагаа
 - Галын хорны бэхэлгээ, ажиллагаа, бэлэн байдал
 - Эмийн сан, анхны тусlamжийн хайрцаг, бэлэн байдал
 - Согтууруулах ундаа хэрэглээгүй байх
 - Ажил эхлэхийн мөнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч, авто машины ашиглалтын заавар, техникийн үзүүлэлтийн дагуу ашиглана.

Ажлын үед:

4. Автомашиныг ашиглалтын зааврын дагуу жолоодох ба хөдөлгөөн эхлэхээс өмнө ажлын талбай дахь аюулгүй байдлыг бүрэн хангасны дараа дуут дохио өгч хөдөлгөөнийг эхлүүлнэ.
5. Дүүргэгч материалыар цэнэглэх үед бункер дотор хүн байгаа эсэхийг шалгах
6. Материалыг халаахдаа ажлыг температурт хүртэл халаах, индикатороор температурыг хянах
7. Ажил гүйцэтгэх явцад бусад тээврийн хэрэгслийг хөдөлгөөнийг бүрэн хаах, тэмдэг байршуулах
8. Асгарсан түлш, тосон дээр халтиирч унахаас болгоомжлох
9. Хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасыг бүрэн өмсөх

Ажил дууссаны дараа:

10. Ажлын дараа машиныг тусгайлан заасан цэгт байршуулах, зогсоолын тормозыг татах, хөдөлгүүрийг унтраан оператороос өөр хүн хөдөлгөх боломжгүй болгох
11. Машины бүрэн бүтэн байдлыг шалган цэвэрлэгээ хийх,
12. Машиныг тэгш бус талбайд байршуулсан тохиололд дугуйд ивүүр хийх

...ооо...

8. Гадаргуун боловсруулалтын / chip seal/ авто машины операторын ажлын үед өгөх аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Гүйцэтгэх ажил:

Асфальтбетон хучилтын ан цав хагарлыг нөхөн элэгдлийн үе хийх

Ажилд гаражын өмнө:

13. Ажлын байранд AMX-р эрсдэлийн үнэлгээ хий.
14. Автомашинд суух, буухдаа машин руу нүүрээ харуулан гурван цэгийн тулгуурын зарчмыг баримтлах
15. Машиныг асаахаас өмнө /унтраасан үед/ үзлэгийг хийнэ. Үүнд:
 - Автомашины хөдөлгүүр, дамжуулах эд анги, явах эд анги /хяналтын систем, хөдөлгүүр, бункер, халаагч, агааржуулалт, ширшигч/ зэргийн бүрэн бүтэн байдлыг шалгах
 - Түлш хүртээмжтэй эсэхийг шалгах
 - Салхины болон бусад шилний харагдах байдал, цууралт зэргийг шалгах
 - Автомашины дугуйн хийн даралт хэвийн эсэхийг шалгах
 - Хянах самбарын ажиллагаа
 - Шил арчигч, дуут дохионы ажиллагаа
 - Галын хорны бэхэлгээ, ажиллагаа, бэлэн байдал
 - Эмийн сан, анхны тусlamжийн хайрцаг, бэлэн байдал
 - Согтууруулах ундаа хэрэглээгүй байх
 - Ажил эхлэхийн мөнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч, авто машины ашиглалтын заавар, техникийн үзүүлэлтийн дагуу ашиглана.

Ажлын үед:

16. Автомашиныг ашиглалтын зааврын дагуу жолоодох ба хөдөлгөөн эхлэхээс өмнө ажлын талбай дахь аюулгүй байдлыг бүрэн хангасны дараа дуут дохио өгч хөдөлгөөнийг эхлүүлнэ.
17. Дүүргэгч материалаар цэнэглэх үед бункер дотор хүн байгаа эсэхийг шалгах
18. Материалыг халаахдаа ажлыг температурт хүртэл халаах, индикатороор температурыг хянах
19. Ажил гүйцэтгэх явцад бусад тээврийн хэрэгслийг хөдөлгөөнийг бүрэн хаах, тэмдэг байршуулах
20. Асгарсан түлш, тосон дээр хальтирч унахаас болгоомжлох
21. Хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасыг бүрэн өмсөх

Ажил дууссаны дараа:

22. Ажлын дараа машиныг тусгайлан заасан цэгт байршуулах, зогсоолын тормозыг татах, хөдөлгүүрийг унтраан оператороос өөр хүн хөдөлгөх боломжгүй болгох
23. Машины бүрэн бүтэн байдлыг шалган цэвэрлэгээ хийх,
24. Машиныг тэгш бус талбайд байршуулсан тохиололд дугуйд ивүүр хийх

...ооо...

9. Индүүний опраторын ажлын үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Гүйцэтгэх ажил:

Замын далан, хөвөө, асфальт бетон хучилтыг нягтуулах

Ажилд гаражын өмнө:

1. Ажлын байранд АМХ-р эрсдэлийн үнэлгээ хий.
2. Суух, буухдаа машин руу нүүрээ харуулан турван цэгийн тулгуурын зарчмыг баримтлах
3. Машиныг асаахаас өмнө /унтраасан үед/ үзлэгийг хийнэ. Үүнд:
 - Хөдөлгүүр, дамжуулах эд анги, явах эд ангийн бүрэн бүтэн байдлыг шалгах
 - Түлш хүртээмжтэй эсэхийг шалгах
 - Салхины болон бусад шилний харагдах байдал, цууралт зэргийг шалгах
 - Хянах самбарын ажиллагаа
 - Шил арчигч, дуут дохионы ажиллагаа
 - Галын хорны бэхэлгээ, ажиллагаа, бэлэн байдал
 - Эмийн сан, анхны тусламжийн хайрцаг, бэлэн байдал
 - Ажилд гараждаа согтууруулах ундаа хэрэглээгүй байх
 - Ажил эхлэхийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан байх.

Ажлын үед:

4. Автомашиныг ашиглалтын зааврын дагуу жолоодох ба хөдөлгөөн эхлэхээс өмнө ажлын талбай дахь аюулгүй байдлыг бүрэн хангасны дараа дуут дохио өгч хөдөлгөөнийг эхлүүлнэ.
5. Ажил гүйцэтгэх явцад бусад тээврийн хэрэгслийг хөдөлгөөнийг бүрэн хаах, тэмдэг байршуулах
6. Асгарсан түлш, тосон дээр хальтирч унахаас болгоомжлох
7. Машин ажиллах шилжилт хөдөлгөөнтэй байгаа үед засвах хийх, техникийн үзлэг хийх, цэвэрлэх, тослохыг хатуу хориглоно.
8. Хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасыг бүрэн өмсөх

Ажил дууссаны дараа:

9. Ажлын дараа машиныг тусгайлан заасан цэгт байршуулах, зогсоолын тормозыг татах, хөдөлгүүрийг унтраан оператороос өөр хүн хөдөлгөх боломжгүй болгох
10. Машины бүрэн бүтэн байдлыг шалган цэвэрлэгээ хийх,
11. Машиныг тэгш бус талбайд байршуулсан тохиололд дугуйд ивүүр хийх.
12. Машины зориулалтын холболтын боолтуудыг авч тавих, өөрчлөн холбохыг хориглоно.

Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 04 дүгээр сарын 10.-ний өдрийн
А/АЧ дугаар тушаалтын хавсралтаар
батлагдсан зааварчилгаа №18

АТА 49 СЬ ФОТО

МАШИН, МЕХАНИЗМ АШИГЛАЛТЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

1. Өөрсдийн хариуцаж байгаа машин механизмын бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллана.
2. Ажлын талбайд ажил эхлэхээс өмнө ажлын хувцас хэрэгслийг зориулалтын дагуу өмсөж, автомашины анхааруулах гэрэл, зогсолтын тэмдгийг байршуулан хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангана.
3. ХАБЭА хариуцсан мэргэжилтнээс аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч гарын үсэг зурсан байна.
4. Машин механизмын ажиллах заавар зөвлөмжтэй танилцаж гарын үсэг зурсан байх.
5. Машин механизмын операторын мөрдөх аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллана.
6. Ажилд гаражын өмнө машин механизм, тоног төхөөрөмжийн ажиллагааг механик инженерээр шалгуулан аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан тохиолдолд ажилд гарна.
7. Машин механизм, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийхдээ удирдах албан тушаалтан хандаж шийдвэрлүүлэн, засвар үйлчилгээг хийлгэнэ.
8. Ажилтан бүр ажил үүргээ биелүүлэх явцад аюулгүй ажиллагааны нөхцөл зерчигдеж хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг, аюултай байдал бий болсон тохиолдолд ажлаа нэн даруй зогсоож, энэ талаар удирдлагадаа яаралтай мэдэгдэнэ.
9. Ажил дууссаны дараа техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалгаж заасан цэгт байршуулна.

...ооо...

Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн
17/14 дугаар тушаалын хавсралтаар
батлагдсан зааварчилгаа №19

ATA 1074

ДИСПЕТЧЕР, ОПЕРАТОРЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР, ЗААВАРЧИЛГАА

Нэг. Ерөнхий зүйл

Монгол улсад дагаж мөрдөж байгаа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм, Зөрчлийн тухай хууль болон Төв-тай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт, байгууллагын дотоод дүрэм журмыг өдөр тутмынхаа үйл ажиллагаанд хэрэгжүүлж, болзошгүй аваар ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор доорхи аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөн ажиллана.

1. Ажил эхлэхийн өмнө ажлын хувцас бүрэн зөв өмссэн байх.
2. Ажлын байрны эмх цэгц, цэвэрлэгээ үйлчилгээг хангаж ажиллах.
3. Ажлын байранд хетлөгдөх бичиг баримтыг бүрэн зөв хөтөлж ажиллах.
4. Ажлын байрны цахилгааны аюулгүй байдлыг хангаж ажиллах.
5. Ажлын байранд галын аюулгүй байдлыг хангаж ил гал гаргахгүй, тамхи татахгүй байх.
6. Ажлын цагийг чанд мөрдөж ажиллах
7. Эзлж хүлээлцэхдээ биечлэн хүлээлцэж байх.
8. Технологи горимыг чанд мөрдүүлж ажиллах.
9. Зохион байгуулалтын нэгжүүдийн мэдээг тодорхой хугацаанд тогтмол авч байх.
10. Харилцагч, хэрэглэгч, ажилтнуудтай харилцаадаа харилцааны соёлтой, ёс зүйн дүрмийг баримтлах.
11. Харилцагч, хэрэглэгчээс ирсэн санал гомдлын дагуу шуурхай ажлыг зохион байгуулж, гомдлыг барагдуулан ажиллах.
- 12.Харилцагч, хэрэглэгч, ажилтнуудыг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллах.
- 13.Аваар, осол, гамшигийн үед удирдлагад цаг алдалгүй мэдээллийг өгч, шуурхай ажлыгзохион байгуулж ажиллах.
- 14.Дээрх нөхцөлд ажиллаж байгаа орчинд доорх зүйлийг анхаарч удирдлагад мэдээлэх:
 - Ажлын орчинд анхааруулах тэмдэг, тэмдэглгээ байршуулсан эсэх,
 - Ажлын хувцас хамгаалах хэрэгслээ бүрэн зөв өмссэн эсэх,
 - Тухайн ажил хариуцан ажиллаж байгаа ИТА ажилтнуудад ажлын чиг үүргийн дагуу зааварчилгаа өгсөн эсэх,
 - Тухайн ажлын талбайд гэрэлтүүлэг, багаж, тоног төхөөрөмж хангалттай байгаа эсэхэд хяналт тавьж удирдлагад болон ХАБЭА-н мэргэжилтэнд мэдэгдэх.
- 15.Гадуур ажил үүргээ гүйцэтгэж явахдаа бэртэж, гэмтэх, бусдын зүй бус үйлдэлд өртөх аюул эрсдэлээс сэргийлж анхаарал болгоомжтой ажиллах.
- 16.Ажилтан таны биеийн байдал тавгүйрхсэн, даралт ихсэн үед өөрийн удирдлагад мэдэгдэж эмнэлгийн анхны тусламж авч ээлжид гараахгүй байх.
- 17.Таньд тулгарсан эсвэл илэрсэн аливаа аюул, аюултай байж болох нөхцөл байдлын талаар байгууллагын ХАБЭА-н хариуцсан мэргэжилтэнд шууд мэдэгдэх.
- 18.Ажилтан та ажлын цагаар, байранд ажлын үнэмлэхийг биедээ тогтмол авч явж байх.

- 19.Ажилдаа согтуу ирэх, ажлын байранд согтууруулах ундааны зүйл хэрэглэхгүй байх.
- 20.Диспетчерийн машинаар зорчихдоо хаалганд гар, хөлөө хавчуулах, толгойгоо цохих эрсдэлээс сэргийлж анхаарал болгоомжтой явах.
- 21.Ажилтан та ажил үүргээ гүйцэтгэж явахдаа анхааруулах, сануулах,хориглох таних тэмдгүүдийг сайтар ажиглаж явах шаардлагатай.
- 22.Газар хөдлөлт, гол гарсан үед авралын гарцыг мэддэг байх. Галын хор ажиллуулах анхан шатны мэдэгдэхүүнтэй байх.
- 23.Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг алдахгүй түргэн шуурхай гүйцэтгэдэг байх.
- 24.Удирдлагад мэдээ, мэдээлэл тайлагнахдаа тодорхой, ойлгомжтой, бичиг хэргийн стандартын дагуу, утга найруулгын алдаагүй байлгах.

Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн
124 дугаар тушаалтын хавсралтаар
батлагдсан зааварчилгаа №20

АТД 1978 ФОРМУЛЫН

ЗАМЫН МАШИН МЕХАНИЗМ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖТЭЙ АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЗААВАРЧИЛГАА

1. Зам барилгын машин, механизм, тоног төхөөрөмж нь үйлдвэрээс дагалдах техникийн паспорт, ашиглалтын заавартай ирдэг бөгөөд ашиглахдаа тухайн машин, тоног төхөөрөмжийг ашиглалтын заавар, техникийн үзүүлэлтийн дагуу ажиллуулж, засвар, үйлчилгээг хийж зориулалтын дагуу ашиглах ёстой.
2. Зам барилгын механизмын оператор, авто машины жолооч доорхи ерөнхий шаардлагыг хангана:
 1. 18 нас хүрсэн, тухайн эзэмшиж буй техникийн ангилалын шаардлага хангасан мэргэжлийн үнэмлэх болон ажилласан тодорхой туршлагатай хүнийг ажиллуулна.
 2. Анх ажилд орохдоо мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын үндэсний төв (МШӨСҮТ)-ын багц үзлэг оношилгоонд хамрагдах ба жилд нэг удаа ажил олгогч нарийн мэргэжлийн давтан үзлэгт хамруулна. Объектын змчийн хяналтанд байнга хамрагдаж, ажлыг хэвийн гүйцэтгэх чадвартай гэдгээ баталгаажуулж байх ёстой.
 3. Ажлыг аюулгүй арга барилаар гүйцэтгэхэд суралцаж, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа авч, ажлын байранд дадлагажиж, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгээ шалгуулж, бие дааж ажиллах зөвшөөрөл авсан байна.
 4. Автомашины явах анги дээр суурилгагдаагүй замын машиныг эдгээр машиныг ажиллуулах эрх бүхий хүн ажиллуулна.
 5. Автомашины явах анги дээр суурилуулсан замын тусгай машиныг операторчны үнэмлэхээс гадна Эрх бүхий байгууллагаас олгосон жолоочийн мэргэжлийн үнэмлэхтэй хүн ажиллуулна.
 6. Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтад байдаг машин, тоног төхөөрөмжийг, тэдгээрийг ажиллуулах эрхийн үнэмлэхээс гадна тусгай сургалтад сууж, сертификат авсан хүн ажиллуулах ёстой.
 7. Байгууллагын тушаалаар томилогдсон хүнд машиныг эзэмшүүлнэ.
 8. Хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд машин, механизмын бүхээгт элдэв гадны зүйл байлгах үйлдвэрлэлийн талбай буюу ажлын байранд гадны зөвшөөрөлгүй этгээд, согтуу хүн оруулахыг хориглоно.
3. Замын машин, механизмын жолооч, операторчид нь үйлдвэрлэлийн бохирдол болон механик нэлээнээс хамгаалахын тулд ажил олгогчоос олгосон MNSISO 13688:2000 стандартын шаардлага хангасан ажлын хувцас, бусад хэрэгцээт хувийн хамгаалах хэрэгсэлүүдийг ажлын талбай, байранд заавал зөв зохистой, тохируулан өмсөж хэрэглэнэ.
4. Ямар нэг эвдрэл гэмтэлтэй, бүрэн бүтэн бус, хаалт хашилтыг авсан машин, механизмыг ажиллуулахыг хориглоно.
5. Машин, механизм, тоног төхөөрөмжийн операторчны ажлын байр, жолоочийн бүхээг нь цэвэр, эмх цэгцтэй байх ёстой бөгөөд багаж хэрэглэл, түлш, галд амархан авалцдаг шингэн, тостой арчилгааны материал байлгаж болохгүй, тусгайлан тоноглосон газарт хадгалах ёстой. Жолоочийн бүхээгт хөөсрүүлэгч гал унтраагч, эмийн сан байх ёстой.
6. Ажлын байр, ажлын хувцас, тоног төхөөрөмжийг үлээлгэхэд тоос сорогчийг хэрэглэнэ. Энэ зорилгоор шахсан хийг ашиглаж болохгүй.

7. Замын машин, механизмыг түлшний задгай агуулахаас 20м-ээс багагүй зайд ажиллуулах ёстой.
8. Түлш, тослох материалыг гал эсэргүүцэх төхөөрөмж ба төмөр гинжин газардуулагчтай машинаар тээвэрлэх ёстой. Түлшний сав руу оч үсрэхээс хамгаалж утааны янданг урагш харуулж, газар луу налуулсан байх ёстой.
9. Ачаа тээврийн машинууд ачаа, материал унах, шороо тоосноос хамгаалсан хашилт, бүтээлэгтэй байх ёстой.
10. Ажил дуусмагц замын машин, механизмын ажлын төхөөрөмжийг газарт буулгаж, машиныг тоормозлож, арааг салгаж, хөдөлгүүрийг унтраах ёстой.
11. Өндөр хүчдлийн шугам, газар доорхи инженерийн шугам сүлжээ, кабельтاي бүсэд замын машин, механизмыг ажиллуулах, явуулахдаа тусгайлан зааварчилгаа өгч, дагалдах хуудсанд нэрийг нь бичсэн инженер-техникийн ажилтны удирдлага дор гүйцэтгэнэ.
12. Экскаватор, ачигч, сумтай кран болон бусад машин, механизмыг, хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугамын дор ажиллуулахыг хориглоно.
13. Цахилгаан дамжуулах агаарын шугамын доогуур машин, механизмыг гаргахдаа тэдгээрийн ажлын төхөөрөмжийг тээврийн байдалд оруулна. Замгүй газарт, машиныг утасны унжилт багатай газраар (тулгуурын орчим) явуулна.
14. Хотын тээврийн хүчдлийг нь салгаагүй шугамын доор сумтай краныг инженер-техникийн ажилтны удирдлагаар ажиллуулна. Ингэхдээ краныг газардуулж, краны сум, хүчдэлтэй шугамаас 1м-ээс багагүй зйтай байх ёстой.
15. Замын механизмын бүрэн ажиллагааг /гэрэл дохио, явах анги/ шалгаж, шилжүүлэх замд саад, аюулгүй бол ойр зайд /1 км хүртэл хөлөөр нь /өөрөөр нь/ шилжүүлж болно.
16. Замын механизмыг трейлэрээр зөөх үед:

 - Ачихын өмнө оператор трейлер тогтвортой зогссон эсэх, зогсоолын тоормозыг ажиллуулсан эсэхийг шалгана.
 - Трейперийн тавцанд бүрэн бүтэн, аюулгүй байдлын үзлэг, цэвэрлэгээг ачаа ачихаас өмнө заавал хийнэ.
 - АЧИХ техникиин гинж оуюу дугуинын дор ивээс тавьж, ажлын төхөөрөмжийг буулган, механизмыг тавцан дээр татлагаар бэхэлнэ. Ойрхон зайд ч заавал бэхэлж байж хөдөлнө.
 - Механизмыг тээвэрлэж явах үеэр бүхээгт нь оператор сууж явахыг хориглоно.
 - Овор ихтэй ачаа тээвэрлэхээс өмнө явах маршрутыг судалж тогтоон урьдчилан жолоочид заавар өгсөн байна.
 - Гүүрээр гарахын өмнө гүүрийн даац, ашиглалтын байдлыг шалгана.
 - Гүүрэн доогуур, нүхэн гарцаар гарахдаа тухайн машин, механизмын овр хэмжээ, гүүрийн доорх овр хэмжээтэй тохирч байгаа эсэхийг шалгана.
17. Гол, горхи гаралаар гатлахад

 - Гатлах голын гүн нь гинжний өндөр буюу дугуйт машины тэнхлэг хүртэл зайнлас их байж болохгүй.
 - Сонгосон гарал нь хатуу ёроолтой байх ёстой.
 - Бүхээгний хаалгыг онгорхой байлгана.
18. Шавар, цасанд суусан машиныг механизмээр чирэхдээ:

 - Огцом хүчтэй татахгүйгээр, хатуу холбоогоор чирнэ.
 - Машины бүхээгний шилийг төмөр сараалж буюу төмөр тороор хамгаалсан

тохиолдолд ган татлагаар чирэх ажлыг гүйцэтгэнэ.

19. Машин чирэх үед оператор дараах үүрэгтэй.

- Машиныг чирэхдээ нэгдүгээр араагаар гүйцэтгэх бөгөөд дохиочны зааврыг анхааралтай дагана. Дохиочин байхгүй тохиолдолд чирэгдэж буй машины жолоочийн зааврыг дагана.
- Маневрлах үед угз татахаас зайлсхийнэ.
- Эхний дохиогоор чирэгч техникийг зогсооход бэлэн байна.

20. Техник үйлчилгээний үеэр оператор хөдөлгүүрийг унтрааж, гидросистемийн цараптыг зогсоно.

21. Механизм, техникийг шатахуунаар цэнэглэж байхад оператор болон ойр орчимд байгаа бусад этгээдэд тамхи татах, ил гол гаргахыг хатуу хориглоно. Машинд шатахуун хийсний дараа урссан тулш, тосыг арчиж, тос болсон эд зүйлийг тагтай металл саванд хийнэ.

22. Цеталь эд ангиудыг угаахдаа этилийн бензин хэрэглэхийг хориглоно.

23. Засвар болон урьдчилан сэргийлэх үзлэг хийх машины дугуйг бат бэх бөгөөд гогтвортой ивүүрээр тулна.

24. Замын машин, механизм нийтийн зориулалттай автомашины замаар зорчихдоо замын хөдөлгөөний хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дурмийг баримтлах ёстой.

25. Хөдөлгүүр нь ажиллаж байгаа машин, механизмыг эзэнгүй орхихыг хориглоно.

26. Оператор ба жолооч нь хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан бүх нөхцөл байдал, үйлдвэрт болсон бүх золгүй тохиолдол, өөрийн эрүүл мэндийн байдал муудах, мэргэжлээс шалтгаалах цочмог өвчин илрэх, хордлогод орох зэрэг үед шууд ажлаа зогсоож, удирдлагадаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

27. Өөрөө явагч машинууд ойрын ба холын гэрэлтэй, урагш хойш явж ажилладаг машинууд (бульдозер, индуу) гэрлийн чиглэлийг тохируулагч арын хоёр гэрэлтэй байх ёстой. Түүнээс гадна хөдөлгүүр зогссон үед ажиллах ослын гэрэлтүүлэгтэй байх ёстой.

1. Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1. Удирдаж буй хүн (инженер эсвэл механик инженер)-дээ ажлыг аюулгүй гүйцэтгэх талаарх мэдлэгээ шалгуулж, үүрэг даалгавар авах бөгөөд ээлж хүлээлцэх бүртгэл хөтөлж, гүйцэтгэх ажлын онцлогтой холбоотой ажлын заавар, ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа авна.

2. Үүрэг даалгавар авсны дараа оператор дараах зүйлсийг хийх үүрэгтэй:

- Удирдах ажилтны хамт машиныг байрлуулах газар нь аюулгүй байдлын тэмдэг тэмдэглэгээ тавигдсан эсэх, бусад машин механизмууд саад болж буй эсэхийг шалгана. Мөн ажил гүйцэтгэх болон аюулгүй ажиллагааны арга хэмжээ авах дарааллыг нарийн тогтооно.
- Машинд үйлчилгээ хийж буй ажилтан болон машин ажиллах ойр орчимд байгаа хүмүүст хөдлөх гэж буйгаа анхааруулах бөгөөд араан дамжуулга нейтраль байрлалд байгаа эсэхийг шалгана.
- Хөдөлгүүрийг асаана.
- Дараа нь ажлын бүх механизм хэвийн эсэхийг хянах самбартaa ажиглаж, хэсэг хугацаанд хий ажиллуулж (нормальдаж), тоormосны ажиллагааг бага зэрэг явж шалгана.

3. Хөдөлгөөн эхлэхийн өмнө ажлын бүсэд хүн, мал байгаа эсэхийг шалгаж, дуут дохио өгнө.

4. Зам дээр буюу ажлын талбайд бусдад саад болохоор зогсох хэрэг гарвал Замын хөдөлгөөний дүрмийн дагуу оврын буюу ослын дохионы гэрэл асааж зогсоно.
5. Ухсан нүх, шуудууны ирмэг дээр эргэх үйлдлийг хориглоно.
6. Тэсэлгээний ажил хийгдэж байгаа үед механизмуудыг тэсэлгээний ажлын удирдагчийн заасан аюулгүй газарт байрлуулж, зөвшөөрсөн дохио өгсний дараа л буцаж очихыг зөвшөөрнө.
7. Хажуу хэвгий газар ажиллах үед операторт дараах зүйлс хийхийг хориглоно:
 - Огцом хөдөлгөөн хийхийг;
 - Машины паспортод заасан хэмжээнээс илүү хэвгийтэй хазгай газарт хөндлөнгөөр явах.
8. Машин явж байх үед бууж суухыг хориглоно.

...оOо...